



**БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын  
2019 оны 2 дүгээр сарын 26-д  
ТООТ ТУШААЛЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

**СУУРЬ БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛ, ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ,  
МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ФИЗИК БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ,  
ТҮҮХ, НИЙГЭМ СУДЛАЛ, ДҮРСЛЭХ УРЛАГ, ХӨГЖИМ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ,  
БИЕИЙН ТАМИР, АНГЛИ ХЭЛ, ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Суурь боловсрол VI-IX анги)**

Улаанбаатар  
2019



**БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДЭСНИЙ  
БИЧИГ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Суурь боловсролын VI-IX анги)**

Улаанбаатар  
2019

### **“Үндэсний бичиг” хичээлийн сургалтын цөм хөтөлбөр (2015)**

|              |  |
|--------------|--|
| Ү.Ариунболд  | Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D       |
| Д.Баттогтох  | Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Ph.D      |
| Д.Заяабаатар | Монгол Улсын Их Сургууль, МХСС-ийн багш, Ph.D                  |
| Б.Батчимэг   | Нийслэлийн 23 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |
| Н.Мөнхцэцэг  | Нийслэлийн 39 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |

### **Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)**

|               |   |
|---------------|---|
| Ө.Цэндсүрэн   | Singapore School of Mongolia сургуулийн захирал, магистр              |
| Ш.Оюунцэцэг   | Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургалтын албаны дарга, магистр |
| Д.Эрдэнэсан   | Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D              |
| Б.Цасанчимэг  | Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч                     |
| Г.Нандинбилэг | Монгол Улсын Их Сургууль, ХШУС-ийн багш, Ph.D                         |
| П.Одсүрэн     | Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, Ph.D               |
| Ц.Туул        | “Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш      |
| А.Энхнаран    | “Байгаль эх” лицей сургуулийн монгол хэл, уран зохиолын багш          |
| Л.Цэдэнсодном | Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр          |

### **Хянан тохиолдуулсан (2019)**

|               |  |
|---------------|--|
| Л.Цэдэнсодном | Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр |
| Ж.Гэрэлмаа    | Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр |

## VI АНГИ: ҮНДЭСНИЙ БИЧИГ

Энэхүү удирдамж нь зургаадугаар ангид үндэсний бичгийн сайжруулсан хөтөлбөрийн дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.



Зорилго: Үндсэн зурлага болон эгшиг, гийгүүлэгч үсгээ ялган таньж, үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг унших, цэвэр цэгцтэй бичиж сурахад оршино.


### УНШИХ


| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн   |
|--|--|--|
| <p><b>6.1а.</b><br/>Дуудлага бичлэг тохирдог үгийг шударга унших</p>                       | <p>Дуудлага бичлэг тохирдог үгсийг хичээл бүрээс тогтмол ялгаж, ийм үгийн сантай болно. Тухайлбал:<br/>“С” үсгийн хүрээнд: сонин, солир, сансар, сал, сав, нис, барс, сор, сур, өс, самар, бос, Самбуу, Сосор,<br/>“Т” үсгийн хүрээнд: тав, тэвэг, толь, тулга, төв, түм, түр, түргэн, таваг, тамир, тэмдэг, тараг, тул, төрөл, дэвтэр<br/>“Ц\ Ч” үсгийн хүрээнд: чимэг, цог, цуг, цэвэр, цахим, цадиг, цэнэг, чи, цэлмэг, цэцэг, цай, цэл, цаг, цахилдаг, чир, цуу,<br/>“З\ Ж” үсгийн хүрээнд: Зар, завсар, зүг, заг, засаг, зэм, зүр, зулзага, зусаг, зэвсэг, зам, зуд, зочин, завсар, зол, зуу, зун<br/>Үзсэн дээрх үгсийн утгыг хэлнэ. Ингэснээр үгээ нүдэлж тогтооно, үгийн баялаг нэмэгдэнэ.<br/>Сурах бичгээс дуудлага бичлэг тохирдог үгсийг найзтайгаа хамтран олоод үндэсний бичгээс кириллд, кириллээс үндэсний бичигт хөрвүүлнэ. Тухайлбал:<br/>ном, нам, он, мал, энэ, эм, бал, бол, ол, өв, гал, баг, ав, хэн, хэв, буй, чи, би, цай, цаг, цуг, цөм, сам, гар, нис, бос, өг, төв, зам, цэцэн, тэнэг, сахал, чимэг, түмэн, далай, хөгжим, цэвэр, бэлэн, сана, бичиг, үнэн болго, уран, олго гэх мэт бичихэд үндэсний бичигтэй адилхан, уншихад кириллтэй адилхан дуудагддаг үгсийг олж, дуудлага бичлэг тохирдог үг бүхий холбоо үг, өгүүлбэр бүтээж үсгээ нүдлэн тогтооно.</p> | <p>Сурах бичгийн үг, өгүүлбэрүүдээс</p>  |
| <p><b>6.1б.</b><br/>Дармал, бичмэл бүхий үг, холбоо үг, хялбар үгтэй өгүүлбэрийг унших</p> | <p>1. Шинэ үсэг нүдлэх үедээ дармал бичмэл үг, холбоо үгийг харьцуулан ажиглаж, ялгааг танина. Сурах бичгийн дасгал 11, 5, 13 г.м<br/>2. Унших үедээ дармал, бичмэл хэлбэрийг хооронд нь хольж сольж алдаад байгаа үсгүүдээ тэмдэглэн багшаас тодруулж асуух. Жишээ нь:<br/>ÿ Эхэнд ордог титэм, шүд, шилбэ<br/>ÿ Үгийн дунд ордог "р, и<br/>ÿ Үгийн дунд ордог "д, т, р, г, х, б"<br/>ÿ Адагт ордог б, у, ү<br/>ÿ Адагт ордог сүүл, орхиц, "г, х, р, и, б" г.м үсгийг харьцуулж ялгааг ажиглах<br/>3. Бүтэн үгээр нь харж унших<br/>Нэлээд хэдэн үсэг үзсэний дараа аль болох бүтэн үгээр нь харж уншина. Ингэхдээ:<br/>- эхлээд нэг үет үг: за, та, чи, би, ол, ном, гар ...гм<br/>- дараа нь хоёр үет үг: уни, хони, ним-а, мину, нэмэ, орун, түмэн ...гм</p>   | <p>сурах бичгийн эхүүд дасгал 8 (х.35)<br/>дасгал 6 (х.34)<br/>дасгал 7 (х.49)<br/>дасгал 2 (х.60) ...гм</p> |

|  |   |  |
|--|---|--|
|  | <p>- түүнээс дээш үетэй үгийг бүтнээр нь харж унших -өмнө уншсан үгсээ холбоо үг болгон унших дадлага хийх.</p> <p>4. Бүтэн үгээр нь харж уншихад төвөгтэй бол үелэн уншина. Тухайлбал: но -м. Эхэнд ордог но гэсэн үе, адагт ордог дэвсгэр м, холбон уншвал ном. Ингэж үе үеэр нь таслан хэлэхээс биш үсэг үсгээр нь таслан хэлэхгүй. Унших үйлийг хийсний дараа дармал сурах бичгийн эхийг бичмэл тигээр хичээнгүй бичнэ.</p> |  |
|--|---|--|

## БИЧИХ

| Суралцахуйн зорилт  | Сурах үйл ажиллагаа   | Хэрэглэгдэхүүн  |
|---|---|---|
| <p><b>6.2а.</b><br/>Үндэсний бичгийн үндсэн зурлагыг харьцуулах аргаар ялган таних, хичээнгүй бичих</p> | <p>- Үндэсний бичгийн тухай сонссон, харсан зүйлээ ярих, магадгүй түрүүлж судалсан бол мэддэг үсгээсээ бичиж сонирхуулах зэргээр мэддэгээ бусадтайгаа хуваалцах мөн бусдын яриаг анхааран сонсох хэрэгтэй. Тухайлбал: кирилл бичгээр хөндлөн бичдэг бол үндэсний бичгээр дээрээс доош босоо бичдэг, кирилл бичгийн дугуй зурлагыг нар буруу эргүүлж бичдэг бол монгол бичгийн дугуй зурлагыг нар зөв эргүүлж бичдэг гм.</p> <p>- Үндэсний бичгээр уншиж, бичиж сурахын тулд хамгийн түрүүнд үндсэн зурлагуудыг ялган танина. Үндсэн зурлагуудыг үзүүлэн, сурах бичгээс болон багш бичиж үзүүлэхэд сайтар ажиглана. Үндсэн зурлагыг ажигласны гол зорилго нь тэдгээрийн ялгааг олох юм. Эндээс зөв уншиж, зөв бичих алхам эхэлнэ. Үндсэн зурлагын ялгааг сайн таньснаар цаашид үсгийг андуурахгүй, мартахгүйгээр зөв, хурдан унших чадвартай болно.</p> <p>- Үндсэн зурлагуудыг ялган таньсны дараа аль болох хичээнгүй сайхан бичихийг оролдоно. Үүний тулд үндэсний бичгийн дэвтрийг ашиглана. Түүнчлэн үзэг эсвэл бал харандааны алинаар нь бичихээ багшаасаа асууж зөвлөнө. Үндэсний бичгийн дэвтрээ нээж, дэвтрийн шугамын хоорондын зай, харьцааг ажиглан, шугамуудыг багшийн зааснаар нэрлэнэ.</p> <p>- Титэм, шүд, шилбэ, гэдэс, нум, сүүл, орхицыг багш самбарт бичихийг ажиглан, бичих тиг хэмжээ ялгаатай болохыг анзаарч ажиглан, багшийн тайлбарт анхаарлаа төвлөрүүлж, улмаар дуурайн бичиж туршин, засаж сайжруулна. Үсэг бүтээх зурлагыг нэрлэх, нэрлээд бичих дадлага хийхдээ аль болох хичээнгүй бичих хэм хэмжээг баримтална. Тухайлбал: титэм бол бүх үсгийн тэргүүнд байх тул жавхаалаг харагдах байдлыг эрхэмлэн, нар зөв эргүүлэн бичнэ. Нуруу нь бүх үсгийг хооронд нь холбох тул тэгш сайхан бичнэ.</p> | <p>"Үндэсний бичиг VI" (2018) сурах бичиг х.6-9 дасгал 1-5 Үндэсний бичгийн дэвтэр</p>   <p>Ш.Чоймаа<br/>Хичээнгүй бичих дасгалын дэвтэр, 2018<br/>"Удам соёл" ХХК</p> |

|   | <p>Шүд – бүх үгэнд жигд нэг хэмээр налуу (45) бичнэ. Гэдэс- дотор нь шүд багтах хэмжээтэй бичнэ. Шилбэ- шүдийг хоёр дахин сунгасан хэмжээтэй, гэдэснээс үл ялиг урт бичнэ. Сүүл- шилбийг хоёр дахин авсан хэмжээтэй, огцом саран хэлбэртэй бичнэ. Орхиц- Хэмжээ нь сүүлтэй адил бөгөөд уран, хурц сайхан үзүүр гаргаж төгсгөнө. Ийм байдлаар гараа зүгширтэл, зурлагуудаа нүдэлтэл хэд хэдэн хуудас бичнэ. 1-р ангидаа кирилл үсгийн зурлагыг гар дасган сурдаг шиг монгол бичгийн зурлага, үсгийг мөн тэгж сурна.</p> <p>- Үүнээс гадна зурлагуудыг нийлүүлж бичих дадлага нэлээд хийнэ. Жишээлбэл:</p> <p>а. Титэм, шүд<br/>б. Титэм, шүд, шилбэ<br/>в. Титэм, гэдэс<br/>г. Титэм, гэдэс, шилбэ гэсэн нийлэмжийг кириллээр бичээд монгол бичгээр бичих, цээжээр бичих гэх мэт алхмаар зурлагуудыг холбон, хичээнгүй бичнэ.</p>  |   |     |     |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |
|---|---|---|-----|-----|-----|-----|-------------|--|--|--|--|------------|--|--|--|--|-------------|--|--|--|--|---|
| <p><b>6.26.</b><br/>Эгшгийг эхэн, дунд, адагт ордог хэлбэрээр гийгүүлэгчийг амилуулан зөв бичих</p> | <p>Үндсэн зурлагыг сайтар ялган таньсны дараа үндсэн долоон эгшгээ ялган танина. Ингэхдээ зурлагыг холбож бичээд титэм эхлэлтэй дүрс үүсгэх, үүсгэсэн дүрсээ хүснэгтэд оноож бичээд нэрлэх, эгшгээ эхэн дунд адагт ордог хэлбэрээр нь бичих, эгшиг үсгийн байрлалын онцлогийн талаар дүгнэлт хийж харьцуулна. Амны хөндийн зайгаар уужим <i>а</i>-аас эхлээд дунд <i>э</i> -г дамжин, уйтан <i>и</i>, <i>улмаар</i> явцуу болж хоёр уруул нийлж хэлэгдэх <i>о</i>, <i>у</i>, <i>ө</i>, <i>ү</i> -ээр төгсөх нь өгүүлэгдэх талаасаа <i>ч</i>, сонсогдох шинжээрээ <i>ч</i>, үсэг зурлага танихын хувьд <i>ч</i> зөв дараалал бөгөөд үүнийг хөгжмийн долоон нооттой адилтган ойлгож болно. Иймд эхлээд цагаан толгойн үндсэн 7 эгшгийг <i>а</i>, <i>э</i>, <i>и</i>, <i>о</i>, <i>у</i>, <i>ө</i>, <i>ү</i> гэсэн дарааллаар дуудаж бичиж сурна. Үндэсний бичигт кирилл бичиг шиг том жижиг үсэг гэсэн ялгаа байхгүй, харин үгийн эхэнд, үгийн дунд, үгийн адагт орох байдлаараа ялгаатайг анхаарах хэрэгтэй.</p> <p>Эгшиг 7 үсгийг эхэнд, дунд, адагт орох гурван хэлбэр нийт 23 хэлбэрийг нэг бүрчлэн таньж нүдлэхэд амаргүй харин адилтгах аргаар ижил үсгүүдийг хураангуйлбал хялбар байх болно. (Үндэсний бичиг VI сурах бичгийн 7-р хуудасны 1-р хүснэгт)</p> | <p>Үндэсний бичгийн сурах бичиг х.6-9 дасгал 1-5, Үндэсний бичгийн дэвтэр</p> <p>Ш. Чоймаа "Таны танил сурах бичиг" (2013)</p> <p>Д.Баттогтох "Үсгийн дүрс төдийнхнийг хувирган өөрөө сурах" (2015) гм ном бүтээл</p> |     |     |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |
|   | <table border="1"> <thead> <tr> <th></th> <th>а/э</th> <th>и</th> <th>о/у</th> <th>ө/ү</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>үгийн эхэнд</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>үгийн дунд</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>үгийн адагт</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>   |   | а/э | и   | о/у | ө/ү | үгийн эхэнд |  |  |  |  | үгийн дунд |  |  |  |  | үгийн адагт |  |  |  |  |  |
|   | а/э   | и   | о/у | ө/ү |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |
| үгийн эхэнд   |   |   |     |     |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |
| үгийн дунд  |   |   |     |     |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |
| үгийн адагт   |   |   |     |     |     |     |             |  |  |  |  |            |  |  |  |  |             |  |  |  |  |   |

|  | <p>Ингээд <b>о/у, ө/ү</b> үсгийг нэг ижил зурлага буюу гэдсээр тэмдэглэдэг тул 5 үсэг болно. Эгшиг үсгүүд үгийн эхэнд бүгд титэмтэй бичнэ. Титмийг орхивол дор үлдэх зурлага нь үгийн дунд орох хэлбэр болох юм. Ижил төстэй эгшгүүдийг багцлан нүдэлбэл сурахад хялбар дөхөм байж болно.</p> <p>Эгшгүүдийг амандаа үглэн хэлж, үсгүүдээ нуруугаар холбон дахин давтан бичнэ. Амандаа хэлж бичвэл тогтоож нүдлэхэд, утгыг ухаарахад, хурдан бичиж сурахад тустайг туршиж үзээрэй. Эр эм эгшиг нэг үгэнд холилдон ордоггүй монгол хэлний энэ ёсны талаар сурах бичгийн 7-р хуудасны 2-р хүснэгтээс үзэж, уншина. Хоёроос дээш үет үг унших үед монгол бичгийн эгшиг зохицох ёсны талаар ажиглаж дүгнэлт гаргана.Тухайлбал: үгийн эхэнд эр эгшиг (а, о, у) байвал хойшид тохиолдох шүд, гэдэс, гэдэс-нум, сүүл, орхицыг цөм эр эгшиг буюу а, у -аар уншина.Үгийн эхэнд эм эгшиг (э, ө, ү) байвал хойшид тохиолдох шүд, гэдэс, гэдэс-нум, сүүл, орхицыг цөм эм эгшиг буюу э, ү -ээр уншина. Үгийн тэргүүн үеэс хойших гэдэс, гэдэс - нумыг эр үгэнд бол у, эм үгэнд бол ү-ээр уншина.</p> <ul style="list-style-type: none"> <li>· Тэргүүн үед “А” орвол дараагийн үеийн шүдийг “А”-аар, гэдсийг “У”-аар дуудна.</li> <li>· Тэргүүн үед “Э” орвол дараагийн үеийн шүдийг “Э”-ээр, гэдсийг “Ү”-ээр</li> <li>· Тэргүүн үед “О\У” орвол дараагийн үеийн шүдийг “А”-аар, гэдсийг “У”-аар</li> <li>· Тэргүүн үед “Ө\Ү” орвол дараагийн үеийн шүдийг “Э”-ээр, гэдсийг “Ү”-ээр дуудан уншина гэх мэт. Монгол бичгийн хэлэнд үгийн тэргүүн үеэс хойш о, ө ордоггүйг тэмдэглэн авна. Сурах бичгийн 9-р хуудасны 2-р дасгалыг хийнэ.</li> </ul> |  |       |       |       |       |                                   |  |  |  |  |                                  |  |  |  |  |                                   |  |  |  |  |   |
|--|--|---|-------|-------|-------|-------|-----------------------------------|--|--|--|--|----------------------------------|--|--|--|--|-----------------------------------|--|--|--|--|---|
| <p><b>6.26.</b><br/>Эгшгийн эхэн, дунд, адагт ордог хэлбэрээр гийгүүлэгчийг амилуулж, дармал бичмэл хэлбэрээр ялган таньж, зөв бичих</p> | <p>Монгол хэл эгшиг амьтай, эгшиг үсгээр гийгүүлэгч үсгүүд амилан үе бүтэж үг болдог. Тиймээс үндсэн 7</p> <p style="text-align: center;">ᠠ ᠨ ᠢ</p> <p>эгшгээ сайтар ялган таньсны дараа</p> <p>гийгүүлэгчийг эгшгүүдийн өмнө тавьж, эхэн дунд адагт хэлбэрээр амилуулан өөрөө бүтээнэ. Үүний тулд:<br/>Эгшгийн эхэн, дунд, адагт ордог хэлбэрээр гийгүүлэгчийг амилуулах нь</p> <table border="1" data-bbox="451 1396 1166 1936"> <thead> <tr> <th></th> <th>на/нэ</th> <th>ни</th> <th>но/ну</th> <th>нө/нү</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>үгийн эхэнд (гийгүүлэгчийн дараа)</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>үгийн дунд (гийгүүлэгчийн дараа)</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>үгийн адагт (гийгүүлэгчийн дараа)</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>   |   | на/нэ | ни    | но/ну | нө/нү | үгийн эхэнд (гийгүүлэгчийн дараа) |  |  |  |  | үгийн дунд (гийгүүлэгчийн дараа) |  |  |  |  | үгийн адагт (гийгүүлэгчийн дараа) |  |  |  |  | <p>Үндэсний бичгийн сурах бичиг х.10-51 дасгал ажлууд<br/>Үндэсний бичгийн дэвтэр</p> <p>Ш.Чоймаа<br/>Хичээнгүй бичих дасгалын дэвтэр, 2018<br/>“Удам соёл” ХХК</p> |
|  | на/нэ  | ни  | но/ну | нө/нү |       |       |                                   |  |  |  |  |                                  |  |  |  |  |                                   |  |  |  |  |   |
| үгийн эхэнд (гийгүүлэгчийн дараа)  |  |   |       |       |       |       |                                   |  |  |  |  |                                  |  |  |  |  |                                   |  |  |  |  |   |
| үгийн дунд (гийгүүлэгчийн дараа)   |  |   |       |       |       |       |                                   |  |  |  |  |                                  |  |  |  |  |                                   |  |  |  |  |   |
| үгийн адагт (гийгүүлэгчийн дараа)  |  |   |       |       |       |       |                                   |  |  |  |  |                                  |  |  |  |  |                                   |  |  |  |  |   |

|  |  |   |
|--|--|---|
|  | <p>н, м, л гийгүүлэгчийг эгшгээр амилуулж бүтээснээ сурах бичгийн 10-р хуудсанд буй хүснэгтүүдтэй тулган зөв амилуулсан эсэхээ шүүн үзнэ. Цаашид бусад гийгүүлэгчийг энэ аргаар амилуулан үгийн эхэн, дунд, адагт ордгоор нь нүдлэн, уншиж, дэвтэртээ хичээнгүй бичнэ. Үг уншина гэдэг нь үеүдийг нийлүүлж уншина гэсэн үг тул үсгээ үзсэний дараа утгатай утгагүй үе бүтээж уншина. Утгатай, утгагүй үе бүхий кириллээс үндэсний бичигт хөрвүүлнэ. Ингэж үсгээ ялган таних, унших бичих дасгал хийж давтана. Уншихдаа үсэглэж биш шууд бүтэн үгээр нь уншина. Хэрэв уншихад төвөгтэй бол үелэн уншина.</p>  |   |
| <p><b>6.2г.</b><br/>Үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг хичээнгүй хуулж бичих</p> | <p>Хичээнгүй бичиж сурахад зөв суух, дэвтрээ зөв тавих, харандаа үзгээ зөв барихаас эхэлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үсгийг хаанаас эхэлж, хаана дуусгаж, аль шугамаас аль шугамд бичиж байгааг багшаа ажиглана.</li> <li>2. Зөв, сайхан тигтэй үсгийн хэв даган бичиж, гараа дасгана.</li> </ol> <p>Хичээнгүй бичиг гэдэг нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүд, шилбэ хоорондоо ялгарахуйц хэмжээтэй.</li> <li>2. Үсгийн налуу 45 градус.</li> <li>3. Үсэг хоорондын зай ижил хэмжээтэй.</li> <li>4. Үсгийн налуу тэгш.</li> <li>5. Нумт үсэг, орхиц сүүл ижил хэмжээтэй байна. Ингэж нэлээд хугацаанд бичиж, гараа дасгана.</li> </ol> <p>Хуулж бичихдээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>· Үгийг зөв шударга унших</li> <li>· Урт үгийг үелэн унших</li> <li>· Чанга дуудан унших зэргээр уншиж, утгыг нь ойлгож байж хуулж бичнэ. Хуулж бичихдээ үг үгээр, үсэг үсгээр мөн холбоо үг, өгүүлбэрээр нь нүдлэн тогтоогоод, үсгийн налуу, хөндлөн босоо харьцааг зөв гарган таван шугамд хичээнгүй сайхан хуулж бичнэ. Үгийг уншиж ойлголгүйгээр, олон дахин харж, шүдийг тоолох зэргээр бичиж болохгүй.</li> </ul> | <p>сурах бичгийн эхээс дасгал 1 (х.х.12)<br/>дасгал 5 (х.18)<br/>дасгал 7 (х.24)<br/>дасгал 13 (х.30)<br/>дасгал 9 (х.50)<br/>дасгал 2 (х.57)...гм.</p>                         |
| <p><b>6.2г.</b><br/>Галигаас үндэсний бичгээр зөв бичих</p>                  | <p>Үндэсний бичгээр бичсэн үг, өгүүлбэрийг үсэг орхилгүй кирилл үсгээр бичсэнийг галиг, галиглах гэдгийг харьцуулан ойлгоно. Галигласан бичвэр, үндэсний бичгийн бичвэрийг хослуулан уншиж үндэсний бичигт хөрвүүлнэ. Ингэхдээ үсгийн эхэнд, дунд, адагт ордог хэлбэрийг сайтар анзаарна. Мөн зураас татаад бичсэн үсгийг тусад нь бичдэг, нэр үгийн нөхцөлийг тусад нь бичдэгийг анхаарна. Эр, эм үгэнд ялгаатай бичдэгийг санана. Галиг бүхий эхийн хувилбаруудыг (өгүүлбэр, үгийн байрыг сольсон) монгол бичгээр бичиж зөв дараалалд оруулан эх бүтээх, галиглан дуудаж өгсөн эхийг монгол бичгээр бичих Сурах бичгийн дасгал 7, 14, 15 гэх мэт. Сурах бичиг дэх галигласан хялбар үг, өгүүлбэр, эхүүдийг үндэсний бичгийн бичвэрийг нь харалгүйгээр үндэсний бичигт хөрвүүлнэ. Бичсэнийхээ дараа монгол бичгийн бичвэртэй нь тулгаж алдаагаа хянана.</p>   | <p>сурах бичгийн эхүүд дасгал 4 (х.17)<br/>дасгал 7 (х.18)<br/>дасгал 4 (х.40)<br/>дасгал 10 (х.25)<br/>дасгал 11 (х.30)<br/>дасгал 5 (х.45)<br/>дасгал 24 (х.79)<br/>...гм</p> |



|   |   |  |
|---|---|--|
| <p><b>6.2д.</b><br/>Сурах бичгийн хүрээний дуудлага бичлэг зөрүүтэй үгийг галигаас үндэсний бичгээр бичих</p> | <p>Сурах бичгийн хүрээнд байгаа үг, холбоо үг, өгүүлбэрээс идэвхтэй хэрэглээний дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг галигаар нь уншина.<br/>Жишээ нь: Идэвхтэй хэрэглээний абу/ аав, гулир/ гурил, эбүгэн, эбүл г.м үгс болон урт, хос эгшигтэй үгсээс галиглан унших<br/>Утгыг дүрсээр ялгасан үгсийг галиглан унших -сурах бичигт байгаа үзсэн үгсийн хүрээнд үгсээс галигаар уншиж, нүдэлнэ. Жишээ нь: нар, нара, нэр -э. г.м үгсийг шууд уншихаас гадна галигаар нь уншиж, бичиж тогтооно.<br/>- Утгыг холбоо үгээр илэрхийж, тайлбарлах<br/>Монгол бичгийн хичээлээр уншиж бичих явцдаа үгийн олон утгыг ойлгож мэддэг. Иймд үгийн утгыг холбоо үгээр илэрхийлж тайлбарлах ба нөгөөтэйгүүр утгыг хэрхэн ойлгосноо холбоо үгээр илэрхийлэн харуулж болно. Тухайлбал: энгхэ мөнгхэ, монггул мөнггү гм.</p> | <p>бэлэг, билиг, бэлгэ (х.35)<br/>сур, тус, сая, хас (х.39)<br/>сар, шар (х.)<br/>гүүр (х.75)<br/>Сурах арын хавсралт толь бичиг</p> |
|---|---|--|

## ХЭЛЗҮЙ

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн                          |
|--|--|---|
| <p><b>6.3а.</b><br/>Нэр үгийг олон тооны дагавар, тийн ялгал, хамаатуулах нөхцлөөр зөв хувилган бичих</p> <p>Дэвсгэрлэх ба үл дэвсгэрлэх ёсыг жишээгээр ангилан бичих, ялган тогтоох</p> | <p>Гийгүүлэгч үсэг үгийн дунд гийгүүлэгчийн өмнө, үгийн адагт эгшиггүй төгсгөж байгаа үгсийг дэвсгэр, ардаа заавал эгшигтэй бичигддэг гийгүүлэгчийг үл дэвсгэр үсэг гэдгийг харьцуулна.<br/>Гийгүүлэгч үсэг нүдлэн таних бүр дэвсгэрлэдэг үл дэвсгэрлэдэг болохыг мэдэж, үсгээ үзэж дуусаад эхээс дэвсгэрлэсэн болон үл дэвсгэрлэсэн үсэгтэй үгсийг түүн, ямар ямар гийгүүлэгч дэвсгэр, ямар ямар гийгүүлэгч үл дэвсгэр болдгийг жагсаан, дүгнэлт гаргана. Үгийн адагт дэвсгэрлэсэн, дэвсгэрлээгүй хувилбараар ордог үсэг бүхий үгсийг галигаар унших- Үүнээс үгийн бичлэгийг ялган тогтоож, дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх ёсны талаар дүгнэх. Түүнчлэн:<br/>- Сурах бичгийн уншсан эхээс гийгүүлэгчээр төгссөн үгийг дотор нь хатуу зөөлөн дэвсгэрээр нь ялгаад, араас нь залгасан нөхцөл нь ямар эхлэлтэй буйг тогтооно.<br/>- Хийсэн үйл ажиллагаандаа үндэслэн дэвсгэр үгсийн онцлог болон нөхцөлийг хэрхэн бичдэг талаар дүгнэлт бичнэ.<br/>- Дүгнэлтээ уншиж танилцуулна, саналаа солилцоно.</p> | <p>х.62</p>                             |
| <p>Жинхэнэ нэрийн олон тооны дагаврыг зөв бичих</p>  | <ol style="list-style-type: none"> <li>1. Сурах бичгээс уншсан эхээс (тооны дагавартай, тийн ялгалын нөхцөлтэй, хамаатуулах нөхцөлтэй) жинхэнэ нэр үгсийг жагсаан бичнэ.</li> <li>2. Эдгээр дагавар, нөхцөл бүхий үгсэд ямар нөхцөл залгасныг задалж тайлбарлана.</li> <li>3. Төгсгөлөөр нь ангилж, жинхэнэ нэр үг нь хэдэн янзын төгсгөлтэй байгааг тодорхойлно.</li> <li>4. Араас нь залгасан нөхцөл нь ямар эхлэлтэй буйг тогтооно.</li> </ol>  | <p>сурах бичгийн х.53-59 дасгал 1-8</p> |

|   |   |                            |                                   |   |                                 |   |
|---|---|----------------------------|-----------------------------------|---|---------------------------------|---|
| <p>Жинхэнэ нэрийг тийн ялгалын нөхцөлөөр зөв хувилгаж бичих</p> | <p>5. Тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөл тус бүрийн эхлэлийг тодорхойлж, дүгнэлт хийнэ.<br/>         6. Хийсэн үйл ажиллагаандаа үндэслэн дэвсгэр үсгийн онцлог болон нэр үгийн нөхцөлийг хэрхэн дагуулах талаар дүгнэлт бичнэ.<br/>         7. Дүгнэлтээ уншиж танилцуулна. Бусадтай саналаа солилцоно. Жишээлбэл: сурах бичиг дэх “Монгол нутаг”, “Монгол хэл”, “Ажлын амт”, “Алт мөнгө хоёр” зэрэг шүлэг, зохиолоос уншина.<br/>         Уншсан шүлгээс олон тооны утгатай үгсийг ялгаж бичих<br/>         - Ниругу-нугуд, агула-нугуд, мөрэн- нүгүд, гоул- уд, зам-уд г.м<br/>         Ялгасан үгсэд байгаа нөхцөлүүдийг эхлэлээр ангилах<br/>         - Гийгүүлэгчээр эхэлсэн (-нугуд, -нүгүд )<br/>         - Эгшгээр эхэлсэн (-уд, -үд)<br/>         Ангилсан нөхцөлөө ямар төгсгөлтэй үгэнд дагуулж байгааг тодорхойлох<br/>         - Эгшгээр төгссөн үгэнд<br/>         - Зөвхөн “Н”-гийгүүлэгчээр төгссөн үгэнд<br/>         - “Н”-ээс бусад гийгүүлэгчээр төгссөн<br/>         Нөхцөлийг үгэнд хэрхэн дагуулж байгааг олж тогтоох<br/>         - Тусад нь дагуулж бичдэг<br/>         - Өмнөх үгэнд залгаж бичдэг г.м дүгнэлг гаргах<br/>         8. Олон тооны дагаврыг зөв бичих дүрмийн хүснэгт бүтээж бусдадаа танилцуулж болно. Үүнтэй адилаар тийн ялгалын нөхцөлийн зөв бичих хүснэгт, хамаатуулах нөхцөлийг зөв бичих хүснэгт бүтээж болно.<br/>         9. Сурах бичигт байгаа эхийг уншаад олон тооны дагавартай, тийн ялгалтай, хамаатуулах нөхцөлтэй үгсийг хэрхэн хэрэглэснийг тайлбарлах</p> |                            |                                   |   |                                 | <p>сурах бичгийн х.60-67 дасгалууд</p>  |
| <p>Жинхэнэ нэрийг хамаатуулах нөхцөлөөр зөв хувилгаж бичих</p>  | <p>Олон тооны дагавраа монгол бичгээр бичнэ үү.</p>   |                            |                                   |   |                                 | <p>сурах бичгийн х.68-70 дасгал 1-5</p> |
|   | <p>Олон тооны дагавраа монгол бичгээр бичнэ үү.</p>   | <p>Хэрхэн галиглах вэ?</p> | <p>Кирилээр хэрхэн дуудах вэ?</p> | <p>Ямар төгсгөлтэй үгэнд дагуулах вэ?</p> | <p>Хэрхэн дагуулж бичих вэ?</p> |   |

Багшид зөвлөх нь:

Үндэсний бичгийн гийгүүлэгч үсэг амилах зүй тогтлыг нь эхний үсгүүдийг үзэх үед судлуулах нь чухал. Үүнийг сайн ойлгуулаагүйгээс болж үсгээ амилуулан уншиж бичихдээ алдах, андуурч буруу унших, алдаатай бичих нь цагаан толгойг үзэж дууссаны дараа ч цөөнгүй тохиолддог. Сурагчид дармал эхийг уншихад бэрхшээлтэй байдаг. Иймд багш сурагчдын унших үйл ажиллагаанд учирч буй бэрхшээлийг судална. Уншиж, бичих үед сурагчид дармал, бичмэлээ андуурдаг. Иймээс шууд уншуулахаасаа өмнө андуурч уншдаг үсгийг дармал, бичмэлээр харьцуулан ажиглуулж дүгнэлт хийсний дараа уншуулах нь үр дүнтэй. Жишээлбэл: Р, И үсгийн дунд адагт ордог хувилбар, Б, У, Ү үсгийн адагт ордог хувилбарыг сурагчид андуурах, хооронд нь сольж буруу унших нь бий.

Хичээнгүй, сайхан бичих нь сурах сэдэл тэмүүллийг нэмэгдүүлдэг давуу талтай ч хэтэрхий их бичүүлж залхаахгүйгээр дэс дараатай бичих үйлд чиглүүлэх хэрэгтэй. Үүнээс гадна үсгийг доорх байдлаар бүлэглэн бичүүлбэл хичээнгүй бичихээс гадна ижил төстэй үсгүүдийг ялган нүдэлж, зөв бичихэд дөхөм болдог. Тухайлбал: • Титэмт үсэг бичих • Шилбэт үсэг бичих • Нумт үсэг бичих • Гэдэст үсэг бичих • Завжит үсэг бичих гэх мэт алхмаар хичээнгүй бичүүлж, хэвшүүлэх хувилбар байж болно.

Сурах бичигт буй үеийн хүснэгтийг харуулахгүйгээр эхлээд өөрсдөөр нь үе бүтээлгэж уншуулах бичүүлэх үйлийг хийж үзэх хэрэгтэй. Ингэснээр сурагчид үндэсний бичгийн үе бүтэх зүй тогтлын талаар мэдлэгтэй болж, идэвхтэй суралцах үйл ажиллагаанд их нэмэр болдог. Үеийн бүдүүвчээр шууд үе бүтээж бичүүлэх, үеүдээр үг болгон уншуулах г.м алхмыг хэрэглэнэ. Мөн дуудлага бичлэг тохирдог үгс болон сурагчдын ихэвчлэн алддаг үгсийг цуглуулан алдааны сан, дуудлага бичлэг тохирдог үгийн сан, идэвхтэй хэрэглээний өвөрмөц бичлэгтэй үгийн сантай болох, карт хийх, түүнээсээ хичээл бүрийн эхэнд бичүүлж болно. Үндэсний бичгийн хичээлээр суралцах чухал зүйлийн нэг нь үгийн утгыг ойлгож мэдэх юм. Үгийн утгыг дүрсээр ялгадаг онцлог монгол бичигт байдаг бөгөөд түүний мөн чанарыг сурагчдад хэрхэн мэдрүүлэхээ бодолцох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, утга дүрс ялгасан үгсийг цээжлүүлж тогтоолгохоос гадна үгийн олон утгыг дүрсээр хэрхэн ялгаж болохыг өөрсдөөр нь бүтээлгээд үзвэл илүү тогтоцтой байх болно.

Хичээнгүй сайхан бичих нь үг дуугүй хуулуулна гэсэн үг биш гэдгийг бид мэднэ. Унших, ярих, сонсох чадварыг аль болох хослуулах хэрэгтэй. Сурагчдын нас сэтгэхүйн онцлог тохирсон өөр хэрэглэгдэхүүнийг сонирхолтой, үр дүнтэй боловсруулж хэрэглэхийг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ боломж багш бүхэнд нээлттэй.

Хэлзүйг заахдаас салангид үг хувилгах төдий аргаас татгалзаж эх, өгүүлбэрийн хам орчноос нөхцөлийн хэрэглээг таниулах нь чухал. Тиймээс сурах бичиг нь хэрэглэгдэхүүн болохоос арга зүй биш юм. Хэрэглэгдэхүүнийг сурах бичгээс шууд хуулбарлаж, дасгал нэг бүрийг биш алийг нь хэрхэн яаж хийлгэх вэ гэдэг аргагүйгээ бодох хэрэгтэй. Мөн бие даан судлан шинжлэх арга барилд хэрхэн удирдахаа төлөвлөнө. Тухайлбал: сурах бичгийн дасгалуудаас сонгон ажлын хуудас боловсруулах, заах аргадаа нийцүүлэн өөрчлөх боломж багшид бий.

Сурагчдыг хэрхэн бүтээлч эрэл хайгуул хийх ажилд удирдан чиглүүлэх вэ? Хэдэн цагийн хичээлийн дараа дүгнэлт хийхдээ багаараа хамтарч бүтээх даалгавар боловсруулах нь сурагчдыг нэгэн хэвийн үйл ажиллагаагаар залхаахгүй давуу талтай байж мэднэ.

Эгшиг, гийгүүлэгч үеийн тогтолцоонд тулгуурлан тийн ялгалын нөхцөлийг нэг дор цогцоор зүй тогтолд нь тулгуурлан таниулах, өөрөөр хэлбэл салангид хэлзүйгээс зайлсхийх аргазүйг эрэлхийлэх нь зүйтэй болов уу. Уншуулж бичүүлэхдээ тодорхой зорилготой үйлийг хийлгэж байх нь сурагчдыг идэвхжүүлж, хичээлийг үр өгөөжтэй болгох давуу талтай.

## VII АНГИ: ҮНДЭСНИЙ БИЧИГ

Энэхүү суралцахуйн удирдамж нь долоодугаар ангид үндэсний бичгийн хөтөлбөрийн дагуу сурахад дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Үндэсний бичгээр бичсэн эхийг зөв дуудан уншиж үг, өгүүлбэрийн утгыг ойлгох, эх орныхоо биет болон биет бус өв соёлоос суралцах, бахархах хандлагыг төлөвшүүлнэ.

### VII АНГИ

#### УНШИХ

| Суралцахуйн зорилт  | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн  |
|---|--|---|
| <p><b>7.1а.</b><br/>Дармал, бичмэл эхийг харьцуулж унших</p>  | <p>1. Дармалаар бичсэн эхийг бичмэл хэлбэртэй нь харьцуулж ялгааг ажиглана.<br/>2. Дармал, бичмэл үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг харьцуулан уншина.<br/>3. Унших үедээ дармал, бичмэл хэлбэрийг хооронд нь хольж, солиод байгаа үсгүүдийг анхаарч ажиглана. Жишээлбэл, үгийн дунд ордог р, и, г, х, адагт ордог г, х, р,и, б, у г.м<br/>4. Бүтэн үгээр нь харж унших.<br/>Андуурах, хооронд нь сольж буруу уншихаас сэргийлж дараах аргаар уншиж туршаарай. Үүнд:<br/>- Давтан уншлагын арга: Давтан давтан чанга уншиж нүдлэн цээжилнэ.<br/>- Нийтээр унших: Бүгд нэгэн зэрэг дуудаж унших явцад бусдыг даган дуурайж зарим үсэг, үгийн алдаагаа засна.<br/>- Багаараа хамтарч унших: Баг бүр өөр өөр эх уншиж бэлдсэнээр бусад багтай сольж уншихад бие биендээ тусалж, алдаа оноогоо хянана.<br/>5. Уншиж утгыг ойлгосны дараа дармал эхийг бичмэл тигээр хичээнгүй бичнэ. (Учир нь дармал үсгүүдийг бичмэлээр болгож бичих нь хүнд байдаг.) Дармал эхийг бичмэлээр бичүүлэх нь дармал бичмэл хэлбэрийг ялган таних чадварыг улам сайжруулдаг. Сурах бичиг дэх дармал, бичмэлээр харьцуулсан эхүүдээс уншиж бичнэ.<br/>6. Дармал бүхий үндэсний бичгээр бичсэн хөнгөн эхийг кириллд буулгана. Буулгаснаа эргүүлээд үндэсний бичигт хөрвүүлнэ.(үндэсний бичгийн эхээ харахгүйгээр) Ингэж өөрийнхөө нүдлэх, унших, бичих, чадварыг сорьж, өөрийгөө чадваржуулж болно.</p> | <p>Сурах бичгийн эхүүд<br/>"Хүмүүн бичиг"</p>   |
| <p><b>7.1б.</b><br/>Гадаад үг, өгүүлбэрийг шударга унших,</p> | <p>Гадаад үг, өгүүлбэрийг шударга уншиж бичихийн тулд:<br/>1. Гадаад үгийг нэмэлт зурлага (матгар шилбэ, сэртэн чих, доошоо харсан зартиг, малгайтай титэм ...) тэмдгээр нь ялгана. Жишээлбэл: "ба" үсгийн толгойд сэртэн чих нэмбэл "фа", ангархай гаргавал "Па", "гэ, хэ"- үсгийн толгойд богино шилбэ татвал "ка", титэм дээр малгай өмсгөвөл "ж", "н" үсэг дэвсгэрлэн, үл дэвсгэрлэн орсон ч ямаргт шүдний өмнө цэг тавина, "у" үсгийг үгийн дунд "ү", үгийн адагт "ү", "д" үсгийг үгийн эхэн, дунд, адагт "ү", "т" үсгийг "ү" -ээр бичдэг гм.<br/>2. Тухайн хэлний үгийг уул бичигт яаж тэмдэглэдэг</p>   | <p>Сурах бичгийн х.108-120<br/>Дасгал 1-30<br/>Сурах бичгийн арын хавсралт толь<br/>Монгол хэлний гадаад үгийн толь<br/>Үндэсний бичгийн толь</p> |

|  |  |  |
|--|--|--|
|  | <p>тэр л байдлаар шууд үсэгчлэн буулгадгийг ажиглаж таньсан байна. Жишээлбэл: кино, клуб, институт, мотор гм.</p> <p>3. Гадаад үг болон гадаад үгийг зөв бичих дүрмийг толь бичгээс лавлан үзсэн байна.</p> <p>4. Өдөр тутам хэрэглэдэг гадаад үгсээ үндэсний бичгээр бичихийн зэрэгцээ монгол үгээр хэрхэн нэрлэдгийг тогтооно.</p> <p>5. Өдөр тутам хэрэглэдэг гадаад үгийг бүртгэн, толь бүтээнэ... Энэ мэт ажлуудыг алхам алхмаар хийж, байнга хэрэглэдэг идэвхтэй гадаад үгийг хэрхэн бичдэгийг нүдэлснээр гадаад үгсийг төвөггүй уншиж бичнэ.</p>  |  |
| <p><b>7.1в.</b><br/>Сурах бичгийн хүрээнд дуудлага бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан унших</p> | <p>1. Утга дүрс ялгасан үгсийг нүдлэхдээ үгийн утгыг хэрхэн дүрсээр ялгаж бичих талаар таамаглаж, өөрөө бүтээж тогтооно. Жишээлбэл: "Зуу" гэдэг үгийн салаа утгыг хэлнэ. зуу - шүд зуу, зуу – арав зуу тоо, зуу -амь зуу, зуу -Эрдэнэ зуу г.м ялгаад дуудлагаар нь эхлээд бичнэ. Дараа нь бусад “зуу” –г хэрхэн ялгаатай бичиж болох хувилбаруудыг бодох. Алдаатай бичсэн ч байж болно. Бичиж дуусаад үгийн утгыг дүрсээр ялгасан зөв хувилбар болон сурах бичиг, толь бичгээс тулган үзэж, өөртөө үнэлэлт өгөөрэй.</p> <p>2.“Зуу” гэдэг үгийн утгыг ялгахын тулд -х, -т, -лга, -лт, -р, -ш зэрэг төгсгөлөөс залгаж олон хувилбараар бичиж үзнэ. Толь бичиг ашиглан хэрхэн зөв бичсэнээ хянана. Сурах бичгийн хүрээнд амар, зоо, хөөр, ичих, мөч, дахин, ур, талаар, хүч, хайр, үр, унах, дэвс ... гм үгс буй.</p> | <p>Сурах бичгийн х.92-105<br/>Дасгал 1-30<br/>Сурах бичгийн арын хавсралт толь</p> |

## БИЧИХ

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн   |
|--|--|--|
| <p><b>7.2а.</b><br/>Бичмэл эхийг хичээнгүй хуулж бичих</p> <p>Үйл үгийн язгуур, үндсийн бичлэгийн онцлогийг таньж, зөв бичих</p> | <p>1. Уншсан эхээсээ үйл үгсийг ялгаж эсвэл тусгайлан ялгасан (тухайлбал, сурах бичгийн хуу.54, 59) үйл язгуур, үндсийг уншина.</p> <p>2. Тэдгээр үйл үгийн төгсгөлийг ажиглаад ялгааг хэлнэ.</p> <p>3. Эгшиг болон гийгүүлэгчээр төгссөн болохыг жишээгээр тайлбарлана.</p> <p>4. Үйл үгийн төгсгөлийн талаар дүгнэх</p> <p>5. Галигаар бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.</p> <p>6. Уг галигласан эхээс үйл үгийг ялгана.</p> <p>7. Ялгасан үйл үгийг язгуур,үндэс, нөхцөлөөр нь задалж бичнэ.</p> | <p>Сурах бичгийн х. 54- 73<br/>Дасгал 1-55<br/>Үзүүлэн</p> |
| <p><b>7.2а.</b><br/>Бичмэл эхийг хичээнгүй хуулж бичих</p> <p>Эгшгээр төгссөн үйл язгуур, үндсийн онцлогийг</p>                  | <p>1. Галигаар бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.</p> <p>2. Уг галигласан эхээс үйл үгийг ялгана.</p> <p>3. Ялгасан үйл үгийг язгуур, үндэс, нөхцөлөөр нь задалж тайлбарлана.</p> <p>4. Өгсөн үйл язгуур, үндсийг уншиж, төгсгөлийг ажиглаад ялгааг хэлнэ.</p> <p>5. Эгшгээр төгссөн үйл үг нь ямар зурлага бүхий ямар ямар эгшгээр төгссөн болохыг жишээгээр тайлбарлана.</p>   |  |

|  |   |   |
|--|---|---|
| таних, зөв бичиж сурах   | 6. Өөрөө эгшгээр төгссөн үйл үг олно.<br>7. Зөв бичсэн эсэхээ толь бичгээс тулган үнэлнэ.   |   |
| <b>7.2б.</b><br>Дармал эхийг хичээнгүй хуулж бичих<br><br>Гийгүүлэгчээр төгссөн үйл язгуур, үндсийн онцлогийг таних, зөв бичиж сурах | 1. Ялгаж өгсөн гийгүүлэгчээр төгссөн үйл язгуур, үндсийг уншина. 2. Тэдгээр үйл үгийн төгсгөлийг ажиглаад, "м, н, л, нг" (зөөлөн дэвсгэр) гийгүүлэгчээр төгссөн, "б, г, р, с, д" (хатуу дэвсгэр) гийгүүлэгчээр төгссөн үйл үг гэж ангилна. 3. Өөрөө гийгүүлэгчээр төгссөн үйл үг бүхий холбоо үг зохиох. 4. Зөв бичсэн эсэхээ толь бичгээс тулган, өөрийгөө үнэлж дүгнэнэ. Дараах асуултад хариулж, өөрийгөө дүгнэж болно.<br>-Үйл үндэс төгсгөдөг гийгүүлэгчийг тоочно уу.<br>-Үйл үндэс төгсгөдөггүй ямар ямар гийгүүлэгч байдаг вэ.<br>-Орхицыг ямар ямар гийгүүлэгчийн доор бичсэн байна вэ.<br>-Сүүлийг ямар ямар гийгүүлэгчийн доор бичсэн байна вэ.                |   |
| <b>7.2в.</b><br>Галиглан бичсэн өгүүлбэр, бичил эхийг үндэсний бичигт хөрвүүлэх  | Өмнөх ангидаа хялбар эх бүхий галигласан бичвэр, үндэсний бичгийн бичвэрийг хослуулан уншиж гэмээнэ үндэсний бичигт хөрвүүлдэг байсан бол үсгийн эхэн, дунд, адагт ордог хэлбэр, зураас татаад бичсэн үсгийг тусад нь бичдэг, нэр үгийн нөхцөлийг тусад нь бичдэг зэргийг бичиж чаддаг болсноор галиг бүхий эхийн хувилбаруудыг (өгүүлбэр, үгийн байрыг сольсноор) монгол бичгээр бичих, зөв дараалалд оруулан эх бүтээх, галиглан дуудаж өгсөн эхийг монгол бичгээр бичих, сурах бичиг дэх галигласан үг, өгүүлбэр, эхүүдийг үндэсний бичгийн бичвэрийг нь харалгүйгээр үндэсний бичигт хөрвүүлнэ. Бичсэнийхээ дараа монгол бичгийн бичвэртэй нь тулгаж алдаагаа хянана. | Сурах бичгийн галигласан эхүүд "Хүмүүн бичиг" |

## ХЭЛЗҮЙ

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа   | Хэрэглэгдэхүүн  |
|--|---|---|
| <b>7.3а.</b><br>Урт, хос эгшгийг тэмдэглэх ёсыг таних<br><br>Урт эгшгийг тэмдэглэх ёсны дагуу урт эгшигтэй үг, холбоо үгийг зөв уншиж, бичих | 1. Сурах бичгээс уншсан эхээс урт эгшигтэй үгсийг олно.<br>2. Урт эгшгийг үндэсний бичгээр яаж, ямар ямар зурлагаар бичсэнийг тайлбарлана.<br>3. Урт эгшиг үүссэн тухай таамаглан ярьж, санал бодлоо хуваалцана.<br>3. ЭГЭ, ЭЭ, Э гэсэн бүтэц тус бүрд оноож бичнэ.<br>4. Кириллээр бичсэн урт эгшигтэй үгийг үндэсний бичгээр хэрхэн бичих талаар таамаглаж, өөрөө бүтээж тогтооно. Жишээлбэл: "Зоо" гэдэг үгийг урт эгшгийг тэмдэглэдэг бүтэц тус бүрээр "зогу", "зоо", "зуу", "зо", "зу" гэх мэт хэрхэн ялгаатай бичиж болох хувилбаруудыг бодож бичнэ. Алдаатай бичсэн ч байж болно. Бичиж дуусаад сурах бичиг болон толь бичгээс үзэж, зөв буруугаа ялган нүдэлнэ. | "Үндэсний бичиг VII" (2018) сурах бичгийн 14-37-р хуудас<br>Дасгал 1-33,<br>Дасгал 1-11<br>Дасгал 1-14<br><br>Ш. Чоймаа "Таны танил сурах бичиг" (2013) |

|   |  |   |
|---|--|---|
| <p>Хос эгшгийг тэмдэглэх ёсны дагуу хос эгшигтэй үг, холбоо үгийг зөв уншиж, бичих</p>                  | <ol style="list-style-type: none"> <li>1. Сурах бичгийн уншсан эхээс хос эгшигтэй үгсийг олно.</li> <li>2. Хос эгшгийг үндэсний бичгээр үгийн эхэнд, дунд, адагт яаж, ямар ямар зурлагаар бичсэнийг тайлбарлана.</li> <li>3. ЭЙИ, ЭИ бүтэц тус бүрд тохирох жишээг оноож бичнэ.</li> <li>4. Кириллээр хос эгшигтэй бичигддэг ч үндэсний бичгээр хос эгшгээр бичигддэггүй үгсийг таньж ялгана. Сурах бичгийн дасгал 18, 22, 24 гм.</li> </ol>   | <p>Сурах бичиг<br/>Дасгал 1-33 (х.40-51)</p>        |
| <p><b>7.3б</b><br/>Холбох эгшгийн дүрмийг таньж, цагаар төгсгөх нөхцлөөр хувилган бичих</p>             | <ol style="list-style-type: none"> <li>1. Сурах бичгийн хүрээнд өгүүлбэр, эх унших явцад тохиолдож буй үйлийн цагаар төгсгөх нөхцөлтэй үгсийг ялгана.</li> <li>2. Ямар нөхцөл залгасныг үгийн бүтцээр задалж тайлбарлана.</li> <li>3. Үйл үгийг төгсгөлөөр нь ангилна.</li> <li>4. Араас нь залгасан нөхцөл ямар эхлэлтэй байгааг тогтооно.</li> <li>5. Холбон бичсэн талаар дүгнэлт хийнэ.</li> <li>6. Хийсэн үйл ажиллагаандаа үндэслэн үйлийн цагаар төгсгөх нөхцөлийг холбож бичих талаарх дүгнэлтээ уншиж танилцуулна. Бусадтай саналаа солилцоно.</li> </ol>   | <p>Сурах бичгийн х.84-89<br/>Дасгал 20-33</p>       |
| <p><b>7.3в.</b><br/>Холбох эгшгийн дүрмийг таньж үйл үгийг зөв хувилган бичих</p>                       | <ol style="list-style-type: none"> <li>1. Галигаар бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.</li> <li>2. Уг галигласан эхээс үйл үгсийг ялгана.</li> <li>3. Ялгасан үйл үгсээ үндэс, нөхцөлөөр нь задална.</li> <li>4. Үйл язгуур, үндсийг төгсгөлөөр нь ангилна.</li> <li>5. Залгаж орсон нөхцөлүүдийг нь мөн ямар эхлэлтэй (ямар ямар гийгүүлэгч) байгааг тодорхойлно.</li> <li>6. Үйл үгийн үндэс, нөхцөл хоёрыг холбож бичихэд зарим үг "гэдэс" авч, зарим үг "гэдэс" авалгүй шууд бичигдсэн байгаа нь юунаас шалтгаалсныг таамаглаж санал бодлоо хуваалцана.</li> <li>7. Дүгнэлт хийх.</li> </ol> <p>Дараах асуултад хариулна.</p> <p>-Дэвсгэр үсгээс аль аль нь үйл үндэс төгсгөдөг вэ? Тэдгээр гийгүүлэгчийг тоочно уу.</p> <p>-Гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд ямар ямар гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгахад "гэдэс" - холбох эгшиг бичдэг вэ.</p> <p>-Ямар ямар гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгахад "гэдэс" -холбох эгшиг бичилгүй шууд залгадаг вэ...</p> | <p>Сурах бичгийн х.76-83<br/>Дасгал 1-19</p>        |
| <p>Сурах бичгийн хүрээн дэх нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг ялган таньж, холбох эгшгийн дүрмээр бичих</p> | <ol style="list-style-type: none"> <li>1. Сурах бичгийн хүрээнд өгүүлбэр, эх унших явцад тохиолдож буй үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үгсийг ялгана.</li> <li>2. Ямар нөхцөл залгасныг үгийн бүтцээр задалж тайлбарлана.</li> <li>3. Үйл үгийг төгсгөлөөр нь ангилна.</li> <li>4. Араас нь залгасан нөхцөл ямар эхлэлтэй байгааг тогтооно.</li> <li>5. Холбон бичсэн талаар дүгнэлт хийнэ.</li> <li>6. Хийсэн үйл ажиллагаандаа үндэслэн үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг холбож бичих тухай дүгнэлтээ уншиж танилцуулна. Бусадтай саналаа солилцоно.</li> </ol>   | <p>Сурах бичгийн х.68, х.7.-83<br/>Дасгал 37 гм</p> |

Багшид зөвлөх нь:

Үндэсний бичгийн хичээлээр суралцах чухал зүйлийн нэг нь үгийн утгыг ойлгож мэдэх юм. Үгийн утгыг дүрсээр ялгадаг онцлог монгол бичигт байдаг бөгөөд түүний мөн чанарыг сурагчдад хэрхэн мэдрүүлэхээ бодолцох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, утга дүрс ялгасан үгсийг цээжлүүлж тогтоолгохоос гадна үгийн олон утгыг дүрсээр хэрхэн ялгаж болохыг өөрсдөөр нь бүтээлгээд үзвэл илүү тогтоцтой байх болно.

Хичээнгүй сайхан бичих нь үг дуугүй хуулуулна гэсэн үг биш гэдгийг бид мэднэ. Унших, ярих, сонсох чадварыг аль болох хослуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сурагчид хэр ойлгож байна, ямар бэрхшээл тулгарч байгааг яриа болон бичгээр илэрхийлж байгаагаас дүгнэдэг. Мөн хичээлийг сонирхолтой болгож, сурагчдыг идэвхтэй оролцуулахын тулд сонгож бичсэн, уншсан зүйлийг тайлбарлуулах, батлуулах, бичсэн зүйлээ хянаж, алдаагаа хэрхэн залруулснаа дүгнэж ярих гэх мэт ярих үйлийг хослуулан ажиллах юм.

Уламжлалт бичлэгтэй үгс, дуудлага бичлэг тохирдог үгс бүхий холбоо үг, богино өгүүлбэр бичүүлэхдээ идэвхтэй хэрэглэгддэг, сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн энгийн, хялбар зүйл бичүүлэхийг эрхэмлэвэл зохино. Тухайлбал: баярын мэндчилгээг богино өгүүлбэрээр илэрхийлэх, дэвтрийн хаяг бичих, өөрийн болон аав ээж, найз нарынхаа нэр, оршин суугаа газар ус, харьяа сум, дүүргийн нэр, сургуулийнхаа нэрийг бичих г.м. Үүнээс гадна сурагчдын нас сэтгэхүйн онцлог тохирсон өөр хэрэглэгдэхүүнийг сонирхолтой, үр дүнтэй боловсруулж хэрэглэхийг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ боломж багш бүхэнд нээлттэй.

Хэлзүйг заахдаас салангид үг хувилгах төдий аргаас татгалзаж эх, өгүүлбэрийн хам орчноос нөхцөлийн хэрэглээг таниулах нь чухал. Тиймээс сурах бичиг нь хэрэглэгдэхүүн болохоос арга зүй биш юм. Хэрэглэгдэхүүнийг сурах бичгээс шууд хуулбарлаж, дасгал нэг бүрийг биш алийг нь хэрхэн яаж хийлгэх вэ гэдэг аргазүйгээ бодох хэрэгтэй. Мөн бие даан судлан шинжлэх арга барилд хэрхэн удирдахаа төлөвлөнө. Тухайлбал: сурах бичгийн дасгалуудаас сонгон ажлын хуудас боловсруулах, заах аргадаа нийцүүлэн өөрчлөх боломж багшид бий.

Сурагчдыг хэрхэн бүтээлч эрэл хайгуул хийх ажилд удирдан чиглүүлэх вэ? Хэдэн цагийн хичээлийн дараа дүгнэлт хийхдээ багаараа хамтарч бүтээх даалгавар боловсруулах нь сурагчдыг нэгэн хэвийн үйл ажиллагаагаар залхаахгүй давуу талтай байж мэднэ. Уншуулж бичүүлэхдээ тодорхой зорилготой үйлийг хийлгэж байх нь сурагчдыг идэвхжүүлж, хичээлийг үр өгөөжтэй болгох давуу талтай.



## VIII АНГИ: ҮНДЭСНИЙ БИЧИГ

Энэхүү суралцахуйн удирдамж нь наймдугаар ангид үндэсний бичгийн хөтөлбөрийн дагуу сурахад дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Үндэсний бичгээр бичсэн эхийг шударга уншиж үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгох, мэдээллийг үр дүнтэй хэрэглэх, уншсан зүйлээсээ суралцах, амьдралд хэрэгжүүлэх эрмэлзэлтэй болж төлөвших.

### УНШИХ

| Суралцахуйн зорилт  | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн  |
|---|--|---|
| <p><b>8.1а.</b><br/>Дармал, бичмэл эхийг галигаар болон орчин цагийн дуудлагаар хослуулан унших аргаар эхийг шууд унших</p> | <p>Эхийг бүтнээр нь чанга тод дуудан унших. Энэ дасгалыг 3-4 удаа давтан хийнэ.</p> <p>Эхийг хэсэглэн, сонголт хийж унших. Жишээ нь: Залхуурлыг яаж дийлнэ гэсэн бэ? Тэр хэсгийг сонгон уншина уу? Эрдэм сурахад юу юу саад болдог гэсэн бэ? г.м</p> <p>Сонгодог бичгийн хэлний дуудлагаар бичсэн хэсгийг сонгож уншина уу?</p> <p>Уншсан эхийг ойлгосноо харуулахын тулд үгийн утга тайлбарлах Жишээ нь: тэвнэ, зусаг, урхи, замбатив, ооно ... Хэллэг: дүр эсгэх, хөл хөсөр, гар газар тавиулах</p> <p>Өгүүлбэр өгүүлбэрээр уншиж кириллээр бичих</p> <p>Эхийн үг хэллэг, өгүүлбэрийн байрлалыг сольсон хувилбарт эхийг унших</p> <p>Унших явцдаа өөрчлөгдсөн хэсгийг өнгөөр будаж тэмдэглэх</p> <p>Эхээс сонирхолтой өвөрмөц үг хэллэгийг түүж унших бичих</p> <p>Хэрэгтэй гэж үзсэн мэдээллийг сонгон авч бичих</p> <p>Таамаглан унших арга (уран зохиолын хичээлээр сурсан) хэрэглэх</p> <p>Уншсан эхэд асуулт тавьж ярилцах</p> <p>Уншсан эхээс үгийн ангилал хийх, танил биш үгийг тэмдэглэх</p> <p>Өмнөх хойтох үгээс болон өгүүлбэр, эхийн утга, агуулгаас ухаарах</p> <p>Шинэ үгийн толь бичиг хөтлөх</p> <p>Эхийг өөртөө болон бусдад шударга уншиж чадаж байгаагаа харуулах</p> <p>Уншсан эхийнхээ сэдэв, гол санааг өөрийн болгохын тулд өөртөө болон бусдад асуулт тавих</p> <p>Чухал гэж үзэж байгаа нь ямар учиртай вэ?</p> <p>Юуг тусган хүлээж авах вэ?</p> <p>Уншсаны дараа юу ойлгосноо хосоор, багаар ярилцана.”.....” холбоо үг орсон өгүүлбэрийг гүйцээж хэлнэ үү? “.....” өгүүлбэрийн дараагийн өгүүлбэр юу гэж байна вэ? “.....” хүний хэлсэн үгийг хэлнэ үү? “.....” гэсэн санаа аль хэсэгт байна вэ? г.м.</p> <p>Эдгээр асуултад хариулж, үндэсний бичгээр зөв уншиж ойлгож чадаж байгаагаа харуулна.</p> | <p>"Үндэсний бичиг VIII" (2018) сурах бичиг</p> <p>Дармал, бичмэл эхтэй бусад эх сурвалж</p> <p>"Хүмүүн бичиг" сонин,</p> <p>Монголын түүхэн сурвалжийн 33 боть, гэх мэт.</p> |
| <p><b>8.1б.</b><br/>Үндэсний зан заншил, сэтгэлгээний онцлог бүхий</p>  | <p>Уншсан эхийн сэдэв, гол санааг өөрийн болгохын тулд өөртөө болон бусдад асуулт тавих</p> <ul style="list-style-type: none"> <li>-Асуултад хариулт олох,</li> <li>- Өөрийн амьдралтай уялдуулан бодох,</li> <li>- Чухал хэрэгтэй санааг олох тайлбарлах</li> </ul>   | <p>"Зуун билиг"</p> <p>Сурах бичгийн эхүүд</p>  |

|  |  |  |
|--|--|--|
| <p>эх, сургаалын зохиолыг шударга унших</p>                          | <p>- Чухал гэж үзэж байгаа нь ямар учиртай вэ?<br/>         - Юуг тусган хүлээж авах вэ?<br/>         Эхэд байгаа үндэсний соёл, зан заншлын холбогдолтой зүйлсийг олох, нэрлэх<br/>         Түүнийгээ эцэг эх, өвөө эмээ, тайлбар толь, нэвтэрхий толиос судлах<br/>         Судалснаа тайлбарлах<br/>         - Энэ асуудал сонирхлыг татсаны учир юу вэ? г.м хүрээнд ярих гм<br/>         Тусган хүлээж авсан чухал гэж үзсэн санаагаа бичиж тэмдэглэж авах<br/>         -Хамгийн чухал гэж үзсэн өгүүлбэрийг хуулж бичих<br/>         - Яагаад чухал гэж үзэж байгаагаа тайлбарлах<br/>         - Чухал санааг хэрхэн хэрэгжүүлэхээ хэлэх<br/>         Сургаалын зохиолуудаас уншиж ойлгох<br/>         - Мэдэхгүй үгээ тэмдэглэн тайлбар толиос утгыг харж унших<br/>         -Урт үет үгийг үелж унших<br/>         -Уншиж чадахгүй үгээ тэмдэглэн найз нөхөд болон багшийн туслалцаатай унших</p>   | <p>"Монгол хүний эрхэмлэх зургаан зүйл" гм ёс заншлын эхүүд</p>  |
| <p><b>8.1в.</b><br/>         Бийрийн хичээнгүй бичгээс зөв унших</p> | <p>Сурах бичиг VIII номд буй бичвүүдийг тухайлбал, дасгал 15 (х.9) , 21 (х.45, 46), 50 (х.59), 57 (х.64), 19 (х.79) ) -д буй бийрийн бичвэрүүдийг уншиж утгыг ярина. Мэдэхгүй, ойлгохгүй үг гарвал тэмдэглэн авч, толь бичгээс харж, бичиж тэмдэглэнэ.<br/>         Бийрийн бичлэг бусад бичлэгээс ямар ялгаатай байгааг сайтар ажиглана. Бийрээр хичээнгүй бичихэд мэдвэл зохих зүйлс гэвэл:<br/>         1.Бичгийн хэрэгсэл: бийр, бэх, янтай, муутуу цаас<br/>         2. Үсэн бийрийг барих гарын байдал: Үсэн бийрээр бичихэд таван хуруу, бугуй, мөр болон бүх биеийн хүчээ бийрийн ишинд төвлөрүүлж, амьсгалаа жигд тайруухан байлгана. Бийр барихад эрхий хуруу нь бийрийн ишийг тулах, долоовор хуруу нь бийрийн ишийг дарах, дунд хуруу нь бийрийн ишийг татах, ядам хуруу нь бийрийн ишийг дотор талаас нь гадагш салган түлхэх, чигчий хуруу нь ядам хуруугаа хамжин түлхэх үүрэгтэй.<br/>         Бийрийн ишээ чанга бөгөөд шулуухан баривал бугуйн хүч, хурууны ид ишинд төвлөрч, бийрийг дээш доош, зүүн тийш, баруун тийш, хойш урагш хөдөлгөхөд хялбар болсноос үсэн бийрийн үзүүрээр сайхан үсгийг бичиж чадна. Бийрээ барихдаа бийрийн ишний голоор, доогуур, дээгүүр нь барих гурван барих арга бий.<br/>         3. Ширээн дээр суух биеийн байрлал: Хичээнгүй бичихэд биеийн байрлал шууд нөлөөтэй. 1.Жижиг үсгийг бичихэд ширээнд сууж бичдэг. Толгой тэгшхэн, бие асхан (тайлбарыг сурах бичгээс үз), цээж тэнүүн, нуруу тэгш, нүдний харц бичих шугамтай аслаж, бийрээ 1-3 ямхын хооронд зайтай дээрээс барьж бичнэ. 2. Нэлээд том үсгийг бичихэд үсгийн зурлага нь урт, бүдүүн байж хөдөлгөөн хийх нь их учир зогсож бичдэг. Зогсохдоо баруун хөлөө бага зэрэг урагш тавьж, баруун мөрөндөө хүч нэмж, зүүн гараараа ширээгээ түших буюу цаасны нэг талыг дараад баруун гарын бугуй тохойгоо өргөж багахан бөхийсхийж бичнэ. 3. Ханан дээр, босоо юман дээр зогсоогоор үсэг бичих. 4. Ширээн дээр бичихэд боломжгүй үед газарт тонгойн сууж бичих гм.</p> | <p>Сурах бичиг VIII номд буй бичвүүдийг тухайлбал, дасгал 15 (х.9) , дасгал 21 (х.45, 46), дасгал 50 (х.59), дасгал 57 (х.64), дасгал 19 (х.79) ) дасгал 13 (х.75) дасгал 26 (х.82) дасгал 15 (125) дасгал 19 (141)-д буй бийрийн бичвэрүүд</p> <p>интернет сайт, Н. Золжаргал "Бийрийн бичлэгт суралцах нь" г.м</p> <p>"Хүмүүн бичиг" - ийн бичвэрүүд</p> |

|  |   |  |
|--|---|--|
|  | <p>4. Бэх идүүлэх, бийр шилэмдэх: Шинэ бийрийг бүлээн усанд дэвтээж цавууг нь гарган, үсийг нь гүйцэд зөөлрүүлсний дараа хэрэглэнэ. Бийрийг бэхэнд гүйцэд дэвтээгээд, янтайн хөвөөнд аажим эргүүлэхийн хамт татаж бөмбийсөн үзүүр гаргахыг бэх идүүлэх, шилэмдэх гэдэг.</p> <p>5. Бийрээ өргөх, бийрээ жигд дарах, бийрээ хүчилж дарах гм өргөлт даралтын тухай</p> <p>6. Үсэн бийрийг хэрэглэх: хэрэглэхээс өмнө бийрээ дэвтээх, хэрэглэсний дараа бийрээ угааж хураах Ийнхүү судлаад, багшийгаа анхааралтай сонсож, бичихийг нь анхааралтай ажиглаж, таван шугамаа татаж бичиж эхэлнэ. Хичээнгүй сайхан бичих нь нэг удаа биш нэлээд хугацаанд уйгагүй оролдсоны дүнд буй болдог. Сурах бичгээс гадна бийрийн бичвэрийг цуглуулж солилцон хуулж бичих</p> |  |
|--|---|--|

## БИЧИХ

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн   |
|--|--|--|
| <p><b>8.2а.</b><br/>Үсгийн бичмэл тигээр өгүүлбэр, эхийг хичээнгүй бичих</p> | <p>Үсгийн бичмэл тигээр үг, өгүүлбэрийг хичээнгүй сайхан хуулж бичих</p> <p>Нийлц дэх зурлага болон харьцааг зөв гаргах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичмэл эхийг хуулж хичээнгүй бичих</li> <li>- Эхийг дээрх байдлаар сайн уншиж ойлгох</li> <li>- Эхэд байгаа богино өгүүлбэрүүдийг түүж хуулж бичих</li> <li>- Дэлгэрэнгүй, нийлмэл (урт) өгүүлбэрүүдийг хуулж бичих</li> <li>- Уламжлалт бичлэгтэй үг орсон өгүүлбэрүүдийг хуулж бичих</li> <li>- "даах, тээш, хөөсөн" гм "... " гэсэн үг орсон хэсгийг хуулж бичих гм</li> </ul> <p>Эхээс сонголт хийж уншаад хуулж бичих. Жишээ нь:<br/>Алдарт монголч эрдэмтэн Николас ПоППегийн дуртгал бүхий эхээс дараах байдлаар бичих:</p> <ul style="list-style-type: none"> <li>-морьтон монголоос юу хүссэнийг,</li> <li>-морьтон монголын хэлсэн үгийг,</li> <li>-өгөх оршихын тийн ялгалтай үг орсон 3 өгүүлбэр байгааг гм.</li> </ul> <p>Хялбар байх үүднээс эхийг эхлээд хэсэглэн, түүвэрлэн хуулна.</p> <p>Дараа нь арай хүндрүүлж эхийг бүтнээр хуулна. Дармал эхийг хуулж хичээнгүй бичих</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичмэл дармал эхийг хослуулан хуулж бичнэ.</li> <li>- 2 өгүүлбэрийг хуулж бичих</li> <li>- "Маймаа" гэсэн үг орсон өгүүлбэрийг хуулж бич</li> <li>- Сарьсан багваахай шөнө нисэж чаддаг нууцыг өгүүлсэн хэсгийг хуулж бич</li> <li>- Урт эгшигтэй үгсийг түүж бич.</li> </ul> <p>Хичээнгүй сайхан хуулж бичихдээ эхлээд эхээ зөв шударга унших. Уншихдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- аль болох бүтэн үгээр харах</li> <li>- Урт үгийг үелэн унших</li> <li>- Чанга дуудан унших</li> </ul> <p>Кириллд хөрвүүлэн хичээнгүй сайхан хуулж бичих</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үсгийн налуу, хөндлөн босоо харьцааг зөв гарган таван шугамд хичээнгүй сайхан хуулж бичих</li> </ul> | <p>"Үндэсний бичиг VIII" (2017) Сурах бичиг</p> <p>Дармал, бичмэл эхтэй бусад эх сурвалж</p> <p>"Хүмүүн бичиг" сонин, гэх мэт.</p> |

|  |  |  |
|--|--|--|
| <p><b>8.2в.</b><br/>Монгол бичгээр бичсэн эхийг зөв шударга уншиж, кириллээр зөв бичих дүрмийн алдаагүй бичих</p>  | <p>Үсэг, үг, холбоо үг, өгүүлбэр уншиж алхам алхмаар суралцсанаар шударга, зөв ойлгож унших чадвартай болох юм. Сурах бичгийн зарим дасгалд буй холбоо үгсийг уншиж байхад аль нэг нь өмнө уншсан танил үг бий. Жишээ нь: дасгал 2-т буй үгсийг уншиж холбоо үг бүтээхдээ өөрийн уншиж бичиж чаддаг үгээр бүтээвэл сонирхолтой байх болно.</p> <p>Холбоо үгсийг бүтээхэд нөхцөлүүдийг таньж мэдэх нь чухал тул тохирох эсвэл өөрийн сайн нүдэлсэн нөхцөлөөр бүтээж болно. Жишээ нь: Дасгал 3, 8, 12, 18 гм.</p> <p>Өгүүлбэрүүд уншихдаа өмнө уншиж байсан хуучин үгсийг эхлэн унших, дараа нь шинэ үгсийг үелэн унших зэргээр уншаад үзээрэй.</p> <p>Уншсан өгүүлбэр, эхээ ойлгосноо харуулахын тулд утгыг тайлбарлах хэрэгтэй. Жишээ нь: тэвнэ, зусаг, урхи, замбатив, ооно ... Хэллэг: дүр эсгэх, хөл хөсөр, гар газар тавиулах</p> <p>Зөвхөн үндэсний бичгийн хичээл дээр л унших биш сургууль ангидаа "хичээлийн хуваарь", "жижүүрийн нэр", "өгсөх шат", "уруудах шат", "орох хаалга" "татна уу" "гарах хаалга", "усаа хаана уу", "баярлалаа" ... гм үгсийг үндэсний бичгээр алдаагүй, зөв хичээнгүй бичвэл өөрсдөдөө үндэсний бичгийн орчныг бүтээж, шударга унших чадвараа ахиулахад том ажил байж болох юм. Шударга унших гэдэг түгдрэлгүй жигд хурдаар, өмнө хойнох үгтэй харьцуулж өгүүлбэр өгүүлбэрээр нь харж унших юм. Тиймээс үндэсний бичгээр уншихдаа үсэглэж уншиж болохгүй. Мөн цээжлэн тогтоогоод уншиж байгаа мэт байдал гаргаж болохгүй.</p> <p>Кириллээр буулгахдаа өгүүлбэр өгүүлбэрээр нь уншина. Өгүүлбэрээр нь уншаад бичихэд гээгдэх эгшгийн дүрэм, томоор бичих, "ж, ч, ш"-ийн дүрэм, үйл үг бүтээх "-л" дагаврыг бичих зэрэг кириллийн зөв бичих дүрмээ санаж бичихэд чухал нөлөөтэй. Үг үгээр уншаад бичихэд үндэсний бичигт нэрийн нөхцөлүүдийг өмнөх үгээс нь салангид, дагуулж бичдэг учир буруу буулгах, баллах зэрэг алдаа гардаг. Эргэлзэж байгаа бол "Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь"-ийг ашиглана.</p> | <p>Сурах бичгийн эхүүд</p> <p>Монгол ардын үлгэрүүд</p> <p>"Эрдэнийн сан Субашид"-аас</p> <p>"Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь"</p> |
| <p><b>8.2в.</b><br/>Сурах бичгийн хүрээний дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх</p> | <p>Дуудлага бичлэг зөрүүтэй үгийн утгыг тайлбарлан уншина.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үгийн жагсаалтыг харааны уншлагаар унших</li> <li>- Уншсан үгээ кириллээр бичих</li> </ul> <p>Үгийн утга тайлбарлах замаар уншсанаа дүгнэж хамгаалах</p> <p>"тул", "өөр", "гол", "хайр" гм гэсэн үгийн утгыг холбоо үгээр илэрхийлнэ. "эмэгтэй хүүхэд" гэсэн утгатай үгийг монгол бичгээр бичихдээ "үхин" гэж бичсэн бичлэгийн ... онцлог байна" гм тайлбарлан хэлэх</p> <p>Үгийг зөв бичих</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үгийг кириллээр бичсэнийг хараад монгол бичгээр оноож бичих</li> <li>- Эхээс олж холбоо үг, өгүүлбэрийн хамт түүж бичих</li> <li>- Бичлэгийн онцлогоор төрөлжүүлэн бичих (урт эгшигтэй, уламжлалт бичлэгтэй гм.) Шар – гэсэн үгийг хэлээд ямар ямар утга байхыг эхлээд олох, дараа нь монгол бичгийн бичлэгийг утгад оноон бичиж тогтоох</li> </ul> <p>· Сурах бичигт байгаа үгийг түүж, нүдэлж тогтоох</p>   | <p>Сурах бичгийн үгс</p> <p>Галигласан эхүүд</p> <p>Үндэсний бичгийн толь</p>  |

|   |  |  |
|---|--|--|
|   | <p>жагсаалтын хэд хэдэн хувилбартай карт бэлдэх<br/> - Жагсаалтыг уншаад кириллээр бичсэний дараа үгийн утга тайлбарлах явцад дуудлага бичлэг зөрүүтэй үгийг зөв уншсан эсэхээ мэдэх боломжтой. (Очир- wci* гм Сурах бичгээс ийм үгийн түүвэр хийх)</p> <ul style="list-style-type: none"> <li>· Дуудлага бичлэг зөрүүтэй үгийг хуулан бичих</li> <li>· Дуудлага ижил, бичлэг зөрүүтэй үгийг ялган бичих</li> <li>· Толгой үсгээр бүлэглэж бичих /айлга, аймаар, гуйх, гүйх, давхар, дэд/ гм</li> <li>· Үгийн утгыг зургаар харуулах</li> <li>· Утгын тайлбарт үгийг нь оноож хэлэх , бичих</li> <li>· Дуудлага бичлэг зөрүүтэй үгийг чээжээр бичих</li> <li>· Янз бүрийн үгийн жагсаалт өгч хуулан бичлэг хийх</li> </ul> <p>Эхийг хэд хэдэн удаа бүтээлчээр уншсаны дараа түүнд байгаа үгсийг толгой үсгээр тольчилж бичих, утгын тайлбар хийж бичих зэрэг янз бүрийн аргаар хийж болно. Жишээ нь: Сүүг ээдүүлж шүүж шахаж хийсэн цагаан идээний төрөл- гм /бяслаг / Сурах бичгийн эхэд байгаа үгсийн жишээ: сод хүмүүс, юм, яагаад, дүн, шан, ган, тойрох, тэнгэр, цацраг, хорт туяа, нүүр, соронзон, тун чухал, хүүхэд, түүх, сониуч, сэрүүлэг дуугарах, шагнал, хор хөнөөл.</p> |  |
| <p><b>8.2г.</b><br/> Толь бичиг ашиглан кириллээс монгол бичигт хөрвүүлэх</p> | <p>1. Юуны тухай, ямар сэдвээр бичих гэж байна вэ? Түүний хүрээнд хэрэглэх үгийг үндэсний бичгээр жагсаан бичнэ. Хэрэв зөв бичиж чадахгүй мэт эргэлзээтэй үгс гарвал толь бичгээс харж бичнэ. Үндэсний бичгийн толь бичигт дагавар, нөхцөлөөр хувилсан байдалтай байдаггүйг санах хэрэгтэй. Тиймээс толь бичгээс үгийн үндсийг бичиж аваад таньж мэдсэн дагавар нөхцөлүүдээ эр эм үг, хатуу зөөлөн дэвсгэрээ санаж, нэр үг бол зөв дагуулж, үйл үг бол зөв холбож бичнэ.</p> <p>2. Сурах бичиг дэх үндэсний бичгээр бичсэн эхийг кириллд буулгаад, буулгасан эхээ үндэсний бичигт хөрвүүлнэ. Ингэхдээ үндэсний бичгийн уг эхээ харахгүй. Дараа нь тулгаж үзэн өөрийгөө үнэлж болно.</p>  | <p>Үндэсний бичгийн толь бичиг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичиг</p> |

## ХЭЛЗҮЙ

| Суралцахуйн зорилт  | Сурах үйл ажиллага   | Хэрэглэгдэхү үн   |
|---|--|---|
| <p><b>8.3а.</b><br/>Нэр язгуур, үндсийг харьцуулах аргаар ялган таних</p> | <ol style="list-style-type: none"> <li>1. Үндэсний бичгээр бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.</li> <li>2. Уншсан эхээс нэр үгсийг ялгана.</li> <li>3. Тэдгээр нэр үгийг төгсгөлөөр нь, үгийн эхний үеийн эгшиг нь өнөө үеийн дуудлагаас ялгаатай байгаагаар нь, үгийн тэргүүн үеийн эгшиг нь өнөө үеийн дуудлагатай адил байгаагаар нь, адил шинжээр нь ангилж, харьцуулан тайлбарлана.</li> <li>4. Сурах бичиг дэх галиглаж бичсэн нэр үгсийг ямар ямар гийгүүлэгчээр (тухайлбал: я, ц/ч, ж/з, с/ш) эхэлсэн болохыг ажиглана.</li> <li>5. Одоогийн дуудлага бичлэгтэй нь харьцуулж, ялгааг олж дүгнэх.</li> <li>6. Хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үндэсний бичгээр бичээд үзээрэй. Алдаатай ч байж болно.</li> <li>7. Бичсэнээ үндэсний бичгийн толь бичгээс үзэж тулган, өөрийгөө үнэлнэ.</li> </ol> <p>Дараах асуултад хариулж үзээрэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Долоон эгшгээс ямар ямар эгшиг нэр үндэс төгсгөдөг вэ.</li> <li>-Эгшгээр төгссөн нэр үндсэнд тийн ялгалын ямар ямар нөхцөлийг дагуулдаг вэ. Жишээгээр тайлбарлана уу.</li> <li>-Үе буюу үгийн үндэс төгсгөдөг н, нг, б, г, д, м, р, с, л эдгээр гийгүүлэгчийг ямар үсэг гэдэг вэ.</li> <li>-Өгөх оршихын -ду, -дү, -ту, -тү нөхцөлүүдийг юугаар төгссөн үндсэнд дагуулдаг вэ...гм</li> </ul> <p>Үгийн төгсгөл оношилж сурах. Жишээ нь: нэр үгийн төгсгөлийг тогтоохын тулд өгөх оршихын “д” “толгойт нөхцөлийг зөөлөн дэвсгэр болон эгшгээр төгссөн үндсэнд, “т” толгойт нөхцөлийг хатуу дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгадаг зүй тогтлыг жишээгээр баталж бичих</p> <p>Кирил үсгийн дүрмээр гар, сар, нар, хэл, нутаг, цаг, нэг, өвс, улс, ус зэрэг ард нь эгшиггүй бичдэг үндсийг өгөх оршихын нөхцөлтэй холбон хэлж шалгавал:</p> <ul style="list-style-type: none"> <li>-гарт гэж хэлэх учраас ардаа эгшиггүй He*</li> <li>-нутагт гэж хэлэх учраас ардаа эгшиггүй Nодо(</li> <li>-цагт гэж хэлэх учраас ардаа эгшиггүй Ce(</li> <li>-улст гэж хэлэх учраас ардаа эгшиггүй Folo_</li> <li>-сард, саранд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй Sera , Se*T</li> <li>-наранд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй Nera</li> <li>-нэрд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй Ne* t</li> <li>-хэлд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй kEla</li> <li>-нэгд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй өвсөнд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй FOEsO</li> <li>-усанд гэж хэлэх учраас ардаа эгшигтэй FEsO гэж шалгаж болно. Шалгах энэ арга бүх нэр үгэнд зуун хувь тохирохгүй ч лав 90 гаруй хувь тохирно. (Ш.Чоймаа)</li> </ul> | <p>Сурах бичгийн х.16-31 дасгал 1-39</p> <p>Үндэсний бичгийн толь бичиг</p> <p>Сурах бичгийн арын хавсралт</p> <p>Ш. Чоймаа<br/>"Таны танил сурах бичиг"<br/>(2013)</p> |

|   |  |  |
|---|--|--|
| <p><b>8.3а.</b><br/>Үйл язгуур,<br/>үндсийг<br/>харьцуулах<br/>аргаар ялган<br/>таних</p>   | <p>1. Галигаар, үндэсний бичгээр бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.<br/>2. Уншсан эхээс үйл үгийг ялгана.<br/>3. Ялгасан үйл үгийг язгуур, үндэс, нөхцөлөөр нь задална.<br/>4. Үйл язгуур, үндсийг эгшгээр төгссөн үйл үндэс, зөөлөн дэвсгэр гийгүүлэгч бүхий үйл үндэс, хатуу дэвсгэр гийгүүлэгч бүхий үйл үндэс гэж ангилж, өнөө үеийн дуудлага бичлэгтэй харьцуулна.<br/>5. Өөрийнхөө өдөрт хийдэг үйлүүдээс үйл үг бүхий холбоо үг бичнэ. (ном унших, тоо бодох, бөмбөг тоглох...г.м) Алдаатай байж болно.<br/>4. Зөв бичсэн эсэхээ толь бичгээс тулган, өөрийгөө үнэлж дүгнэнэ. Эдгээр үйл ажиллагааг хийсний үндсэн дээр асуултад хариулах замаар дүгнэлт хийж болно. Жишээлбэл:<br/>-Үйл үндэс төгсгөдөг гийгүүлэгчийг тоочно уу.<br/>-Үйл үндэс төгсгөдөггүй ямар ямар гийгүүлэгч байдаг вэ.<br/>-Орхицыг ямар ямар гийгүүлэгчийн доор бичдэг вэ.<br/>-Сүүлийг ямар ямар гийгүүлэгчийн доор бичдэг вэ...г.м<br/>Үйл үндсийн төгсгөлийг мэдэж зөв бичихэд:<br/>ü Үйл үгийг төгсгөлөөр нь ангилж бичих<br/>ü Уншсан эхээс үйл үгийг түүж үндэс залгавраар задлах, задалсан хэсгээ төгсгөлөөр нь ангилах<br/>ü а, э төгсгөлтэй үйл үгийг эхээс түүж бичих, үг нэмж олох<br/>ü Нөхцөлийг эхлэлээр нь төрөлжүүлж бичих<br/>ü Нөхцөлийг зөв холбон бичих<br/>· Үйл үгийн төгсгөлийг тогтоож бүлэглэх<br/>· Эхээс үйл үгийг түүж бичих. Ингэхдээ сонголттойгоор:<br/>- хоёр дахь өгүүлбэрт байгаа үйл үгийг түүж бичих<br/>- эзний үйлүүдийг түүж бичих<br/>- сургасан үйлүүдийг түүж бичих гм<br/>· Түүж бичсэн үйл үгийг төгсгөлөөр нь бүлэглэж бичих<br/>· нбдрсл - төгсгөлөөр бүлэглэх<br/>· Бүлэглэсэн үгсийг баяжуулж үг нэмж бичих</p> | <p>Сурах бичгийн х.16-31<br/>дасгал 1-39</p> <p>Үндэсний бичгийн толь бичиг</p> <p>Сурах бичгийн арын хавсралт</p> <p>Ш. Чоймаа<br/>"Таны танил сурах бичиг"<br/>(2013)</p>  |
| <p><b>8.3в.</b><br/>Үйл үгийн<br/>төгсгөлд<br/>тохиолдох<br/>дэвсгэр үсгийг<br/>тодруулан,<br/>холбох эгшгийн<br/>дүрмээр зөв<br/>бичих</p> | <p>Үндэсний бичгээр бичсэн эхийг уншиж, утгыг ойлгоно.<br/>Уг уншсан эхээс үйл үгсийг ялгана.<br/>Ялгасан үйл үгсээ үндэс, нөхцөлөөр нь задална.<br/>Үйл язгуур, үндсийг төгсгөлөөр нь (эгшгээр төгссөн, зөөлөн дэвсгэр үсгээр төгссөн, хатуу дэвсгэр үсгээр төгссөн) ангилна.<br/>Залгаж орсон нөхцөлүүд ямар ямар гийгүүлэгчээр эхэлсэн байгааг тодорхойлоод залгавруудыг хувилгагч (й, г, н, м, р, схи, шгүй толгойтой залгаврууд), эс хувилгагч (ж, ч, б, с, д, х, т толгойтой залгаврууд) гэж хоёр хэсэгт ялгана.<br/>Үйл үгийн үндэс, нөхцөл хоёрыг холбож бичихэд зарим үг "гэдэс" авч, зарим үг шууд залгаж бичсэн байгааг тайлбарлана.<br/>Холбох эгшгийн дүрмийн дагуу зөв бичих талаар дүгнэлт гаргана. (Холбох эгшгийн 1-р дүрэм, 2-р дүрэм. х.36)<br/>Эдгээр үйл ажиллагааг алхам алхмаар хийж дараах асуултад хариулах замаар дүгнэж болно.<br/>-Дэвсгэр үсгээс аль аль нь үйл үндэс төгсгөдөг вэ? Тэдгээр гийгүүлэгчийг тоочно уу.<br/>-Гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд ямар ямар гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгахад холбох эгшиг бичдэг вэ.<br/>-Ямар ямар гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгахад холбох эгшиг бичилгүй шууд залгадаг вэ...гм<br/>Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийг бүлэглэж сурах нь чухал. Ж</p>   | <p>Сурах бичгийн х.36<br/>дасгал 5-11</p> <p>Сурах бичигт байгаа эхийг олон янзаар ашиглах<br/>Жишээ нь:<br/>"Ус ба тогтвортой хөгжил" (х.104)<br/>зэрэг эх дээр</p> <p>Сурах бичигт байгаа эхийг олон янзаар ашиглах<br/>"Цэцэн бэрийн нүүдэл" (х.19),<br/>"Үндэсний бахархалт цэцэг" (х.39),</p> |

|  |   |  |
|--|---|--|
|  | <p>нь: –л гийгүүлэгчээр төгссөн үйл үг гэх зэргээр төгсгөлөөр нь бүлэглэн жагсааж бичих</p> <p>Үйл үгийн нөхцөлийн утга хэлбэрийг ойлгож тогтоох</p> <ul style="list-style-type: none"> <li>· Эхээс үйл үгийг түүж бүтцээр задлах</li> <li>· Үгийн бүтцэд байгаа нөхцөлийг олж тогтоох</li> <li>· Үгийн талаарх таамаглалаа гаргаж ойлголтоо зөв болгож, батлах</li> <li>· Тухайн үгийнхээ утгыг тайлбар толь бичгээс харах, бусдаас асуух замаар мэдэж авах</li> <li>· Үгийн бичлэг өөрийн таамаглалтай чинь нийцэж байгаа эсэхийг тунгаах</li> <li>· Дэвтэрт нэмэлт эгнээ үүсгэж бичих</li> <li>· Эхээс түүж бичсэн үйл үгийг бүгдийг зөвхөн кЕоа геоа нөхцөлөөр хувилгах</li> <li>- Тэдгээр үйл үгээ зөвхөн K&amp; -go&amp; нөхцөлөөр хувилгах</li> <li>- Тэдгээр үйл үгээ зөвхөн kcl eecI нөхцөлөөр хувилгах</li> <li>- Тэдгээр үйл үгээ зөвхөн ksea eesea нөхцөлөөр хувилгах</li> <li>- Тэдгээр үйл үгээ зөвхөн kEsel gesel нөхцөлөөр хувилгах</li> <li>- Тэдгээр үйл үгээ зөвхөн Kjel gojel нөхцөлөөр хувилгах</li> </ul> | <p>"Ус ба тогтвортой хөгжил" (х.104) зэрэг эх дээр -уламжлалт бичлэгтэй үг (өглөө...)</p> <p>- урт эгшигтэй үг (уурга, агаар, уудам, доор, шувуухай, гартаам, аав, хүү, шүү, дээр...)</p> <p>-дуудлага ижил бичлэг өөр үг (бэлэг...)</p> <p>-хамтын уншлагаар чанга тод дуудан унших</p> <p>-Хэсэглэж унших, түүж унших</p> <p>-бүтнээр хуулах,</p> <p>-онцолж хэлснийг хуулж бичих</p> <p>-хэлзүйн онцлогоор түүж бичих:</p> <p>-хэвийн дагавартай үг</p> <p>-байдлын дагавартай үг</p> <p>-тодотгон холбох нөхцөлтэй үг</p> <p>-нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үг</p> <p>-одоо цагаар төгсгөх нөхцөлтэй үг түүж бичих гм.</p> |
|--|---|--|



|  |   |                           |                         |          |   |                                       |   |
|--|---|---------------------------|-------------------------|----------|---|---------------------------------------|---|
| <b>8.3в.</b><br>Хэвийн дагаврыг таньж үйл үгийн үндсэнд холбох эгшгийн дүрмээр бичих   | <p>Үйл үгийн хэвийн дагавартай үг, өгүүлбэрийг уншиж, утгыг ярина.</p> <p>Хэвийн дагавартай үйл үгсийг бүтцээр задална. Хувилгагч үсгүүдээр эхэлсэн хэвийн дагавруудын дүрмийг тайлбарлана.</p> <p>Хэв дагавар бүхий үндсэнд хувилгагч, эс хувилгагч үсгээр эхэлсэн нөхцөл, дагаврыг хэрхэн бичсэнийг ажиглаж дүгнэлт гаргана. Жишээ нь: найирагул -ху, -гчи, -даг, -г-а, -й-а...</p> <p>Хэвийн дагавруудыг хэрхэн залгаж бичсэнийг ажиглаад дагавар тус бүрийн дүрмийг тайлбарлана.</p> <p>Мөн дагавар тус бүрийн утгыг жишээгээр тайлбарлана.</p> <p>Дараах байдлаар дүрмийн хүснэгт бүтээгээрэй.</p> |                           |                         |          |   | сурах бичгийн х.40-59<br>дасгал 23-49 |   |
|  | Хэвийн дагаврын нэр   | Одоогийн дуудлага, хэлбэр | үндэсний бичгийн хэлбэр |          | дэвсгэр үсгээр төгссөн үгэнд шууд залгана | эгшгээр төгссөн үгэнд бичнэ.          | "Үндэсний бахархалт цэцэг" (х.39),                                    |
|  |   |                           | эр үгэнд                | эм үгэнд |   |                                       | "Ус ба тогтвортой хөгжил" (х.104) зэрэг эх дээр -хэвийн дагавартай үг |
|  | өөрөө үйлдэх  |                           |                         |          |   |                                       | -байдлын дагавартай үг  |
|  | бусдар үйлдүүлэх  | уул, үүл                  |                         |          |   |                                       | -тодотгон холбох нөхцөлтэй үг   |
|  |   | лга4                      |                         |          |   |                                       |   |
|  |   | га/гэ (ха/хэ)             |                         |          |   |                                       |   |
|  |   | аа4                       |                         |          |   |                                       | -нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үг                                     |
|  | бусдын эрхэнд үйлдэгдэх   | гд                        |                         |          |   |                                       | -одоо цагаар төгсгөх нөхцөлтэй үг түүж бичих гм.                      |
|  | харилцан үйлдэх   | лд                        |                         |          |   |                                       |   |
| хамтран үйлдэх   | лц  |                           |                         |          |   |                                       |   |
| Бичих дуртай, эгшиг болон гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд хэвийн дээрх дагавруудыг холбож, өгүүлбэрт оруулан хэлэх. Холбож бичихдээ эр, эмээ санах. Бичсэнээ найзтайгаа солилцон өөрсдийгөө үнэлж болно. |   |                           |                         |          |   |                                       |   |
| <b>8.3в.</b><br>Байдлын дагаврыг таньж   | Байдлын дагаврыг үйл үндсэнд дагуулж бичсэн жишээг ажиглаад, дагавар бүрийн зөв холбож бичих дүрмийг тайлбарлана. Жишээ нь:   |                           |                         |          |   | сурах бичгийн х.61-67<br>дасгал 51-62 |   |

|  |  |  |   |                                    |   |   |
|--|--|--|---|------------------------------------|---|---|
| үйл үгийн үндсэнд холбох эгшгийн дүрмээр бичих   | байдлын дагаврын нэр   | одоогийн дуудлага, хэлбэр                                | Жишээ   | хатуу дэвсгэрээр төгссөн үгэнд     | зөөлөн дэвсгэр ба эгшгээр төгссөн үгэнд | Сурах бичигт байгаа эхийг олон янзаар ашиглах "Үндэсний бахархалт цэцэг" (х.39),<br><br>"Ус ба тогтвортой хөгжил" (х.104) зэрэг эх дээр -хэвийн дагавартай үг -байдлын дагавартай үг -тодотгон холбох нөхцөлтэй үг -нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үг -одоо цагаар төгсгөх нөхцөлтэй үг түүж бичих гм. |
|  | энгийн үйлдэх  | 0  | хара-, хэлэ-, сур-, ол-, өг-                      |                                    |   |   |
|  | бүрмөсөн үйлдэх  | чих  | харачиха, хэлэчихэ, сурчиха, өгчихэ, олчиха       |                                    |   |   |
|  | эрчимтэй үйлдэх  | схий   | йабусхи, гүйүсхи, өггүсхи, сурусхи, олусхи        |                                    |   |   |
|  | түр үйлдэх   | зна4   | йабузана, хэлэзэнэ, сурзана, өгзэнэ, олзана       |                                    |   |   |
|  | олноороо үйлдэх  | цгаа4  | харацага, үзэцэгэ, сурцага, өгцэгэ, олцага        |                                    |   |   |
|  | Зөв сайхан бичдэг, эгшиг болон гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд хэв болон байдлын дагавруудыг давхар залгаж холбон бичиж, өгүүлбэрт оруулан утгыг тайлбарлах. Бичсэнээ багшдаа үзүүлж, шалгуулж болно.  |  |   |                                    |   |   |
| <b>8.3в.</b><br>Тодотгон холбох нөхцөлийг таньж үйл үгийн үндсэнд холбох эгшгийн дүрмээр бичих | Үйл үгийн тодотгон холбох -х, -аа (гүй), -сан, -даг4, -маар, -хуйц, -гч нөхцөлтэй үг, өгүүлбэр, эхийг уншиж, утгыг ярина. Тодотгон холбох нөхцөлтэй үйл үгсийг ялгаж бүтцээр задална. Хувилгагч үсгүүдээр эхэлсэн тодотгон холбох нөхцөл тус бүрийн холбож дүрмийг тайлбарлана. "хана-, чинэ-, туна-, суна-" гэсэн "н"-ээр төгссөн үйл үндсэнд -х нөхцөл залгахад ямар өөрчлөлт гарсныг жишээгээр тайлбарлана. Уншсан эхээс тодотгон холбох нөхцөлтэй 15 үгийг олох... гм. Дасгал 35 |  |   |                                    | Сурах бичгийн х.70-89 дасгал 1-40       |   |
| <b>8.3в.</b><br>Нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг таньж үйл үгийн үндсэнд холбох дүрмээр зөв бичих | Нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үгсийг уншиж, ажиглана. Нөхцөлүүдийг хувилгагч, эс хувилгагч шинжээр нь ангилж, дэвтэртээ бичнэ. Тухайлбал:  |  |   | Сурах бичгийн х.92-113 дасгал 1-40 |   |   |
|  | нөхцөлийн харьцуулал   | хувилгагч нөхцөл (дэвсгэр үсгээр төгссөн үгэнд залгахад) | эс хувилгагч нөхцөл (ямар ч үндсэнд шууд залгана) |                                    |   |   |

|   |   |                                     |
|---|---|-------------------------------------|
|   | гэдсээр холбоно)  |                                     |
|   | одоогийн дуулага, хэлбэр  |                                     |
|   | Үндэсний бичгийн хэлбэр   |                                     |
|   | <p>"ав, хөв" гэдэг үйл үгийн хувиллыг ажиглаад, "жив" гэдэг үгийг хувилгана. Тухайлбал: сурах бичгийн х.95, дасгал 4. Ингэж зарим өвөрмөц хувилдаг заншилтай үгсийг тодруулна. Жишээлбэл: өг-, хана- чинэ- туна- суна-, түүнчлэн дэвсгэр "д" үсгээр төгссөн үгс.</p> <p>Гийгүүлэгчээр төгссөн нэг үйл үгийг нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүдээр хувилгаж нүдлээрэй. Хувилгахдаа эр, эм, хатуу зөөлөн дэвсгэр зэргийг санах.</p>  |                                     |
| <p><b>8.3в.</b><br/>Цагаар төгсгөх нөхцөлийг таньж үйл үгийн үндсэнд холбох эгшгийн дүрмээр зөв бичих</p> | <p>Сурах бичиг дэх эхийг уншиж, утгыг ярина.<br/>Уншсан эхээс цагаар төгсгөх нөхцөлтэй үгсийг ялгаж бичнэ.<br/>Ялгасан үгсээ үгийн бүтцээр задална.<br/>Хувилгагч үсгүүдээр эхэлсэн нөхцөлүүдийг ялгаж, зөв холбож бичих дүрмийг тайлбарлана.<br/>"ав, хөв" гэдэг үйл үгийн хувиллыг ажиглаад, "жив" гэдэг үгийг хувилгана. Тухайлбал: сурах бичгийн х.95, дасгал 4. Ингэж зарим өвөрмөц хувилдаг заншилтай үгсийг тодруулна. Жишээлбэл: өг-, хана- чинэ- туна- суна-, түүнчлэн дэвсгэр "д" үсгээр төгссөн үгс.<br/>Гийгүүлэгчээр төгссөн нэг үйл үгийг цагаар төгсгөх нөхцөлүүдээр хувилгаж нүдлээрэй. Хувилгахдаа эр, эм, хатуу зөөлөн дэвсгэр зэргийг санах.</p> |                                     |
| <p><b>8.3в.</b><br/>Биеэр төгсгөх нөхцөлийг таньж үйл үгийн үндсэнд холбох эгшгийн дүрмээр зөв бичих</p>  | <p>Сурах бичиг дэх эхийг уншиж, утгыг ярина.<br/>Уншсан эхээс биеэр төгсгөх нөхцөлтэй үгсийг ялгаж бичнэ.<br/>Ялгасан үгсээ үгийн бүтцээр задална.<br/>Хувилгагч үсгүүдээр эхэлсэн нөхцөлүүдийг ялгаж, зөв холбож бичих дүрмийг тайлбарлана.<br/>"ав, хөв" гэдэг үйл үгийн хувиллыг ажиглаад, "жив" гэдэг үгийг хувилгана. Тухайлбал: сурах бичгийн х.95, дасгал 4. Ингэж зарим өвөрмөц хувилдаг заншилтай үгсийг тодруулна. Жишээлбэл: өг-, хана- чинэ- туна- суна-, түүнчлэн дэвсгэр "д" үсгээр төгссөн үгс.<br/>Гийгүүлэгчээр төгссөн нэг үйл үгийг биеэр төгсгөх нөхцөлүүдээр хувилгаж нүдлээрэй. Хувилгахдаа эр, эм, хатуу зөөлөн дэвсгэр зэргийг санах.</p>   |                                     |
|   |   | сурах бичгийн х.116-131 дасгал 1-32 |
|   |   | сурах бичгийн х.134-143 дасгал 1-24 |

Багшид зөвлөх нь:

Эхийн гарчгаас харвал юуны тухай өгүүлсэн бол гэж таамаглуулах нь тухайн сэдвийн хүрээнд унших үгийн хэрэглээ, бичлэгийг баримжаалахад хэрэг болох юм. Хувилбартай үсгүүдийг зөв хувилбараар нь унших зэргийг уншихын өмнө байнга сануулж чиглүүлэх. Харааны уншлагаар унших, хамтран, тод чанга дуугаар унших үйлийг хослуулах. Харааны уншлага нь өөртөө итгэх, хариуцлагатай сурах, бодож тунгаах боломж олгодог бол хамтын уншлага нь алдаагаа засах хэл яриа, дуудлагаа зөв цэвэр болгоход боломж олгодог. Уншиж чадахгүй байгаа үгийг орхихдоо “тэмдэглэх цаас” ашиглан бичүүлж болно. Тэр цаасыг хоорондоо солилцоод кириллээр бичиж буцаан өгөхөд хүүхэд юу гэсэн үг болохыг мэднэ. Энэ нь багш шууд хэлж өгөхөөс илүү өөр нэг хүүхэд унших чадвараа хөгжүүлж хэдэн ч хүүхдийн “тэмдэглэх цаас”-ыг уншиж өгөх юм. Мөн анги нийтээр чанга дуугаар хамтын уншлага хийхдээ сурагчдыг харандаа бариулж уншиж чадахгүй байгаа үгийг зурж орхихыг зөвлөөрэй. Дахин хэд хэдэн удаа унших явцад нөгөө зурж орхисон үгийг юу гэж дуудаж байгааг мэдэж уншдаг болно. Дараа нь эхийг хэсэглээд баг бүрд өгч мөн чангаар уншуулна. Дараа нь солиод уншуулаарай.

Ярилцах нь монгол хэлний хичээлээс өөр юм. Ярихын тулд заавал эргэж унших шаардлага үүсэхүйц асуулт даалгавар байх нь монгол бичгийн хичээлийн онцлог.

Энэ удирдамжид оруулсан эхүүдийг монгол бичгээр өгөх юм. Энэ хэсэглэл нь хэсэг бүрд байгаа үгийн онцлогтой холбоотой.

1. Нөхцөлүүдийн уламжлалт хэлбэрүүд бүхий

2. Биеэр төгсгөх нөхцөл бүхий

3. Хэв байдлын дагавар бүхий хэсэг

4. Орчин цагийн дуудлага бичлэгээр бичих гэх зэргээр онцлогийг харгалзан хүүхдийн чадвар, сурах арга барилын онцлогт тохируулан хуваарилж уншуулж болно. Солин өгч уншуулна. Хэсэглэхээс гадна сонголт хийж унших боломж олгохдоо сайн чадах хэсгээ, сайн уншиж сурмаар байгаа хэсгээ гэх зэргээр сонгуулна. Шударга сайн уншиж сурахад үгийн дуудлагыг зөв дуудах, утгыг сайн мэдэж байх нь чухал тул утгын тайлбарыг орхигдуулахгүй байх хэрэгтэй.

· Эдгээр эхээс аль нэгийг сонгож унших боломж олгоно. Ингэхдээ 3 эхийг зааж өгнө. Эхийн гарчгийг уншаад сонгоно.

· Эхийг ерөнхийд нь гүйлгэж хараад сонголт хийх

· Эхлэл хэсгийг хараад сонголт хийх аргуудаас хэрэглэхийг зөвлөнө. Эдгээр эх нь үгийн тоо ойролцоо тул хүүхдүүдийн унших хугацаанд нэг их зөрүү гарахгүй. Эхний сонголтоор уншсан эхийн утгыг ойлгосон байдал нь дараагийн үйл ажиллагаа болох бусдаар уншуулахаар ятгахдаа хэрхэн жишээ татаж тайлбарлаж байгаагаас харагдана. Энэ байдлыг багш сайтар ажиглаж хэн уншиж ойлгосон, хэн нь уншиж ойлгоогүй байгааг мэднэ. Ижил эх сонголтоор нь баг бүрдүүлж хамтран унших байдлаар /зарим хүүхэд дагаж унших боломжтой болдог/ унших хурдыг сайжруулна.

Унших явцад онцолсон тодруулсан үгийг түүж бичүүлнэ.

Хос хосоор чанга дуугаар уншихад уншлагын байдал сайн ялгарахгүй тул нөгөө хос нь үг бүрээр анхааралтай сонсож буруу уншсан үгийг тэмдэглэнэ. Энэ нь явцын үнэлгээ болж болно.

Том цаасан дээр монгол бичгээр бичсэн өгүүлбэрийг цувуулан байрлуулж ард нь кириллээр бичих зай орхиж анги, коридорт байрлуулна. Сурагчид үг, өгүүлбэр гээд аль уншиж чадсанаа зайнд нөхөж бичнэ. Ард нь нэрээ бичнэ. Энэ нь нэг талаар бие даах ажил болж өргөжиж ч болно.

Сонирхолтой болгох, эрж хайх, анхаарч тогтоох, утгыг мэдэх зэрэг хэд хэдэн үйлийг давхар хийх боломжийг хувилбарт эх олгоно. Эхийн агуулга утгыг алдагдуулахгүйгээр бага зэрэг хувиргал буюу байр сэлгэлт хийж уншуулбал сурагчид тааж, дуурайж унших бус нүдэлж тогтоон ойлгож уншдаг болно.

Уншсан эхээс үгийн ангилал хийх, гаргалгаа хийх, харьцуулах зэрэг нь эхийн агуулгыг ойлгоход чиглэсэн үйл юм. Иймд сонгосон эхэд ямар, ямар чиглэлээр ангилал хийж болохыг төлөвлөнө. Жишээ нь: “э+г+э” бүтцэд хамаарах үгийг түүж хэлэх г.м

Аман зохиол нь ирээдүй хойч үеэ сургасан сургамж захиас, мянга мянган жилийн амьдралын туршлагаа өвлүүлэх арга зам юм. Нэгэнт олон мянган жилийн турш ард түмнээр “зүлгэгдэж, өнгөлөгдсөн”-ий хувьд хамгийн энгийн үгээр асар гүн утга илэрхийлдгээрээ гайхамшигтай учир аман зохиолын баримтуудыг хэрэглэгдэхүүн болгох нь тун зохистой.

Монгол бичгээр бичсэн эхийг кириллд буулгах нь уншиж чадаж байгааг харуулах тул уншиж ойлгох үйлийн нэг хэсэг гэж үзнэ. Сурагчдаар монгол бичгийн эхийн цуглуулга хийлгэх нь тэдний сонирхсон сэдвийнх нь хүрээнд унших чадварыг хөгжүүлэх нэг арга юм. Тэдгээр эхийн сангаас нь уншуулж кирилл бичигт буулгахаас гадна бусдын цуглуулсан эхээс бас сонирхлын дагуу сонголт хийж уншаад түүнийгээ кириллд буулгах боломжтой. Цуглуулга хийлгэвэл тэдгээр эхэд буй үгийн давтамжийг түүлгэн монгол бичгээс хуулан бичих даалгавар өгөх замаар чадваржуулж болно. Ингэхдээ хичээлийн сэдвийг тодорхойлохдоо аль болох чадварт чиглүүлэх. Жишээлбэл: “Эхээс сонгож кирилл бичигт буулгах”, “Үгийн утга ойлгож кириллд буулгах” гм. Ингэвэл тэр хичээлээр ямар ямар үгийн утгыг шинээр мэдэж түүнийгээ үндэсний бичгээр уншиж кириллд буулгаж чаддаг болсныг хялбархан харуулах юм. Хичээлийн сэдэв: “3 өгүүлбэр сонгож кириллд буулгах” Ийм хичээлийн хувьд сурагч бүр өөрийн чадварт тохируулан чадвараа ахиулахуйц өгүүлбэрүүдийг сонгон авч кириллд буулгах боломжтой болно. Кириллд буулгах чадвар нь монгол бичгээр уншиж ойлгож чадаж байгаа, монгол бичгээр бичсэн үгийн бүтэц зүй тогтлыг мэдэж байгааг харуулна.

Галиглан унших нь зөв бичихэд хэрэгтэй ч зарим чадварлаг сурагчдын хувьд шууд унших боломж олгох нь илүү үр дүнтэй. Харин монгол бичгээр унших чадвар сайн эзэмшээгүй сурагчдад галиглах нь илүү үр дүнтэй. Галиг ба монгол бичгийн эхийг хамтад нь өгөөд уншуулсны дараа галиг- монгол бичгийн үг хоёрыг нэг эгнээнд бичүүлнэ.

Кириллээс монгол бичигт буулгах үед хялбар биш тул эхлээд ямар өгүүлбэр, эхийг монгол бичгээр бичих вэ гэдэгт сурагчдаар өөрсдөөр нь сонголт хийлгэвэл хүүхэд өөрийн чадварт тохируулах юм. Багш нэгдсэн нэг эх өгөх нь янз бүрийн чадвартай хүүхдүүдийн хувьд харилцан адилгүй үр дүн харуулдаг учраас зарим нь чадахгүйгээгээсээ болж залхуурч цөхөрдөг. Хэрэв бичих зүйлийг нь өөрөөр нь сонгуулбал хүүхдүүд өөрсдөө урьдчилан өгүүлбэр эхээ цуглуулан бэлддэг болж багш ч тэр бүр хэрэглэгдэхүүн цуглуулах шаардлагагүй болно. Жишиг даалгавар Хувилбар 1 нь уншиж ойлгох, бичих чадварыг бүхэлд нь багтаасан дараах хуудсыг бэлдэнэ. Энэ хувилбар нь бичих чадвар сул байгаа бол галигаас буулгахаар өгсөн байхад хувилбар 2 нь кириллээс монгол бичигт буулгахаар боловсруулсан байх жишээтэй. Гэхдээ 2-т өмнө нь уншиж байсан танил эхийг сонгоно. Ингэхдээ ойлгосон байдлыг давхар харгалзахаар тооцож ..... нөхөж гүйцээж бичнэ.

Аажмаар танил бус эх рүү шилжих байдлаар хийвэл тохиромжтой.

Хуулан бичүүлэх хичээлийг гол төлөв хоёр янзаар явуулна.

а. Багшаас хуулан бичүүлэхээр сонгон авсан эхээ самбарт хичээнгүйлэн бичиж түүнийгээ сурагчдаар хэд хэд уншуулан цэвэр сайхан алдаа мадаггүй хуулан бичүүлнэ.

б. Багш урьд өмнө хуулж бичсэн эхийн зарим үг /тийн ялгалын дагавартай, хөнгөн үгс/-ийг орхиж бичээд сурагчдаар орхисон үгсийг нөхөн хуулуулж бичүүлнэ. Энэ нь сурагчид хуулан бичсэн үгсээ хэр нүдэлж байгааг давтан сургах сургалт юм.

Өнгөрсөн олон зуун жилийн дотор монголын олон аймаг, нутгийн хэл ярианд буй болсон зарим авиан өөрчлөлт гарчээ. Энэ өөрчлөлт нь эрт цагт тохирч байсан бичлэгийн журмаас зарим талаар гажих болсон байна. Хэлдгээрээ бичиж болох уу хэмээвээс одоогийн хэллэгээр бичиж болно. Хэрэв ингэж бичих болбоос: 1. Эртнээс уламжилж биедээ шингээсэн авиа зүй, үг зүйн онцлог, үгийн үндэс их хувиар эвдрээд, хэлний шинжлэлд толь болдог нь үгүй болно. 2. Монголын өөр аялгуут нутаг нутгийн ард түмнийг холбож чаддаг чадлаа алдаж, ганц нэгэн нутгийн бичиг болж хувирна. Тавиад жилийн өмнө монгол бичгээр бичсэн ном бичгийг халимаг, дөрвөд, буриад, өвөр Монголын олон аймаг цөм нэгэн адил ойлгодог, мэддэг байсан билээ. Халхын аялгуунд ах, эх, нөхөр гэж байхад буриадад аха, эхэ, нүхүр гэж хэлдэг. Халхад өндөр, өндөг гэдэг бол баргад үндүр, үндүгэ гэнэ. Халхад нас, үс гэдэг, Цайдамын монголд насун, үсүн гэж байдаг. Адил бичлэгийн дүрмээр бичээд өөр өөрийн нутгийн аялгуугаар уншиж болдгийн жишээ энэ бөгөөд олон аялгуут монголчуудыг холбож чаддагийн учир үүнд юм. (Д.Чойжилсүрэн Монгол улсын Ардын багш) 3. Монгол бичгийн зөв бичгийн дүрэмд эртнээс нааш толь бичгээр уламжилж ирсэн хэвшмэл бичлэг байдаг. Тэдгээрийг зөв бичгийн журамласан толь бичгийн тусламжаар цээжлэн нүдлэх нь сургалтын нэг арга мөн. Энэ нь юуны түрүүн ижил дуудлагатай үгсийг өөр дүрээр ялган бичих журам юм

Төгсгөлийг нүдлүүлэхдээ эгшгээр төгссөн нэг үетэй, эгшгээр төгссөн хоёр үетэй, гийгүүлэгчээр төгссөн нэг үетэй, гийгүүлэгчээр төгссөн хоёр үетэй гм —ээр бэлдэнэ. Энэ нь сурагчдын сурах явцын ялгаатай байдлыг гаргахад дөхөмтэй, ялгаатай хэрэглэгдэхүүн болно.

Цаг, биеэр төгсгөх, тодотгон, нөхцөлдүүлэн холбох, хэв, байдлын нөхцөл дагавруудыг хувилгагч эс хувилгагчаар нь бүлэглэн багцалж заах боломжтой.

Үндэсний бичгийн хичээл нь үндэсний соёл зан заншлыг судлан зэмших, хэрэглэх, хадгалан хойч үед үлдээх тул ийм агуулга бүхий эх бичвэрүүдийг сонгон уншуулахад анхаарна. Зүгээр уншуулаад орхих бус түүнийг эзэмшиж хэрэглэх сэтгэлгээ хандлага төлөвшүүлэхэд анхаарах юм. Монголын ард түмний уламжлалт ертөнцийг үзэх үзлийн илэрхийлэл болсон ардын ёс заншил, бэлгэдэл, өв уламжлалын жишээг ашиглах нь дээр өгүүлсэн зорилгыг биелүүлэхэд бүрнээ нийцнэ. Учир нь үндэсний уламжлалыг агуулсан зан заншил бол хүний амьдралыг зохицуулагч оюун санааны хэм хэмжээ юм. Ямар ч улс үндэстэн өөрсдийн ахуй орчин, аж амьдрал, үзэл бодол, гоо сайхны таашаал, ёс суртахууны хандлага, нийгмийн зан төлөвийн тодорхой байдлыг бэлгэдэн илэрхийлсэн өв уламжлал, ёс заншилтай байдаг. Хичээлийн хэрэглэгдэхүүнээр үндэсний хувцастай холбоотой эх сонголоо гэхэд үндэсний хувцас маань олон мянган жилийн аж амьдралд нийцсэн, зан төрх, гоо сайхны таашаал, үндэсний сэтгэхүйн онцлог шинжийг тусгасан, тухайн газар орны цаг агаарын ааш араншин, хүн зоны эрхэлж ирсэн аж ахуйтай нягт уялдан зохицсон байдаг учир энэ талаар гүнзгий мэдлэг эзэмших боломжтой болох юм.

## IX АНГИ: ҮНДЭСНИЙ БИЧИГ

Энэхүү баримт бичиг нь есдүгээр ангид үндэсний бичгийн хөтөлбөрийн дагуу сурахад дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Унших явцдаа эхийн утга санааг илэрхийлсэн арга, хэлбэр, хэл найруулгыг ажиглан шинэ мэдээллийг үр дүнтэй ашиглах чадвар эзэмшиж, уншсанаа хэрэгжүүлэх эрмэлзэлтэй болж төлөвших. Бичих зорилго, төлөвлөгөөндөө нийцүүлэн байгаль хамгаалал, ёс суртахууны сэдвээр асуудал дэвшүүлэн, уялдаа холбоотойгоор сэтгэн бичих чадвар эзэмшиж, санаа бодлоо гүнзгийрүүлье гэсэн эрмэлзэлтэй болж төлөвших.


### УНШИХ

| Суралцахуйн зорилт  | Сурах үйл ажиллагаа   | Хэрэглэгдэхүүн  |
|---|---|---|
| <p><b>9.1а.</b><br/>Дармал, бичмэл, бийрээр бичсэн эхийг хурдан, шударга уншиж ойлгох</p> | <p>Эхлээд дармалаас уншина. Дараа нь эхэд гарч буй үсгийг бичмэлээр задалж бичнэ. Жишээлбэл: "учиртай" гэдэг үгийн "у" үсгийн титэм, "р" үсгийг дармалаас бичмэл рүү дэвтэртээ задлан бичнэ. Ийнхүү задлан бичих явцдаа дармал, бичмэл тигийн ялгааг гаргана. Дармал, бичмэл үсгийн тигийг дараах байдлаар анзаарч ажиглана.</p> <p>А. Үсгийн титэм ямар ялгаатай байна.<br/>Б. Үгийн адагт орсон сүүл ямар ялгаатай байна.<br/>В. Цацлага ямар ялгаатай байна.<br/>Г. Адагт орсон " Б" ямар ялгаатай байна.<br/>Д. Дунд орсон дэвсгэр Д ямар ялгаатай байна.<br/>Е. Адагт орсон дэвсгэр Д ямар ялгаатай байна.<br/>Ё. Р үсгийн эхэн, дунд, адагт орсон байдал ямар ялгаатай байна.</p> <p>Одоо дармал эхээ хараад бичмэл рүү хуулж бичнэ. Хуулж бичихдээ бичмэл эхээс дуурайлган хуулж бичих, дармал эхээс хичээнгүй цэвэр сайхан бичмэл тиг рүү бичих гм өөр өөр байдлаар бичвэл үр дүнтэй.</p> <p>Дармал, бичмэл эхийг харьцуулан уншиж, утгыг бүрэн ойлгон, гол санааг ялгана. Үүний тулд унших явцад ухаж ойлгохгүй байсан үг хэллэг, бүтээвэр зэргийг тэмдэглэн монгол хэлний тайлбар толь, багшаас асууж сурвалжилна. Тухайлбал: "дөрөө мултлах", "гаваар орох", "халуун зуур", "хаван бөх" ...гм үсгийг тодруулах (унаанаас буух, ан цаваар орох, ойр зуур, зэрлэг азарган гахай) Түүнчлэн "явбаас, асарваас, хүргэвээс, хүртээвээс..." зэрэг үсгийн нөхцөл нь орчин цагийн монгол хэлний – вал, -вол, -вэл, - вөл гэсэн хэлбэртэй утга дүйнэ. "харийн газраа" – "газраа" гэдэг үгийн –аа нь орчин цагийн монгол хэлний “ – т, -д” дагавартай утга дүйнэ гэх мэтээр ойлгож авна.</p> <p>Уншсан эхийн утгыг ойлгосноо харуулж бусдад тайлбарлан ярина.</p> | <p>"Үндэсний бичиг IX" (2017) сурах бичиг</p> <p>Дармал, бичмэл эхтэй бусад эх сурвалж</p> <p>"Хүмүүн бичиг" сонин,</p> <p>Монголын түүхэн сурвалжийн 33 боть, гэх мэт.</p> <p>Ш. Чоймаа "Таны танил сурах бичиг" (2013)</p> <p>"Монгол бичгийн зөв бичих дүрмийн хураангуй мэдлэг шалгах сорил" (2014) гм ном бүтээл</p> |
| <p><b>9.1б.</b><br/>Уншсан эхээс түүхэн үг, хэллэгийн утгыг тольчлон тайлбарлах</p>       | <p>"Чингис хааны билиг сургаал", "Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир", "Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээх сургаал оршив" зохиолуудын хэсгээс</p> <p>1. Зохиолыг уншина.<br/>2. Эхээс ойлгохгүй байгаа түүхэн үг хэллэгийг түүж бичнэ. Үүнд: "Зововч хичээлийг мэлзээнд гаргана" гэсэн өгүүлбэрийг ойлгоход бэрхшээлтэй байна гэвэл Мэлзээ – гэдэг үгээ үйл үг болгоно. "мэлзэх" гэдэг үг үүснэ.</p>  | <p>Сурах бичиг дэх "Чингис хааны билиг сургаал" "Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир" гм зохиолууд</p>  |

|  |   |   |
|--|---|---|
|  | <p>"мэлзэх" гэдэг үгээ монгол хэлний тайлбар толиос харна. "хэлсэн, хийсэн явдлаа үгүйсгэж ор тас зүтгэх, буцах, няцах" гэх мэт мэтгэх үйл явцыг хэлнэ. "мэлзэх" гэсэн үгээр холбоо үг үүсгэнэ. "улалзтал мэлзэх", "худлаа мэлзэх". "Хичээл" гэдэг үгийг мөн үйл үг болгоно – хичээх: тайлбар толиос харвал "шамдаж чармайх, идэвх оролдлого гаргах, санаа тавих" утгатай. Холбоо үг үүсгэвэл "хувиа хичээх", "эзэн хичээх", "хичээлдээ хичээх" гм. "мэлзээ", "хичээл" гэдэг 2 үгийн утгыг өөрөө задлан шинжилж мэдсэн учраас өгүүлбэрээ тайлбарлах гэж оролдоно. "Зововч хичээлийг мэлзээнд гаргана" гэдэг нь "Санаа зововч өөрийгөө тайвшруулан цагаатган залхуурч хичээл сурлага ажил амьдралдаа эс шамдахыг хэлж байна" гм</p> <p>Энэ арга барилаар уншсан зохиолын түүхэн үг хэллэг, сургаал үгсийн утгыг тайлбарлаж болно.</p> <p>Бас нэг арга бол унших явцдаа эхээс оноосон нэрийн доогуур зурах, оноосон нэрийг түүж бичин түүхийн хичээлтэйгээ холбон тухайн хүн, газар нутаг, оршин байсан он цаг хугацааг бусад мэдээллийн сангаас олж мэдэх юм.</p> <p>3. Өөрийн тайлбараа нягталж тайлбар толь бичгээс харж, багшаасаа тодруулж утгыг бүрэн ухаж мэднэ. Аль болох толь бичигтэй ажиллах нь чухал.</p> <p>4. Үгийн сангийн дэвтэр, толь бичгийн дэвтэр, үгийн утгын дэвтэр гм дэвтэр нээж шинээр мэдэж авсан үгээ тэмдэглэн хөтөлнө.</p> <p>5. Уншсан эхийн гол санааг тайлбарлаж, өөртөө тусган авах ямар зүйл байгааг ярина.</p> | <p>“Монгол зуун билгийн дээж оршвой” зохиолын сургаалын эхүүдээс</p> <p>Монгол хэлний тайлбар толь</p> <p>Монгол хэлний хуучин үгийн толь</p> <p>Монгол хэлний үгийн гарлын толь</p>                                      |
| <p><b>9.1в.</b><br/>Түүх, соёл, өв уламжлал бүхий монгол бичгийн хичээнгүй, дармал, хулсан үзэг, бийрийн хэлбэрээр бичсэн түүхэн зохиол судар бичгээс сонгон унших</p> | <p>1. Эхийг уншина. Уншихдаа эх дуудлагаар нь уншина. Зарим үгийг гаргаж чадахгүй бол үеэр таслан \qa-ma-ya-la-qu\ хэлнэ.</p> <p>2. Уншиж чадахгүй үгээ дэвтэртээ бичнэ.</p> <p>3. Дэвтэртээ бичсэн үгээ утгат хэсгээр задална. Жишээ нь: \sang+na+gul+qu\ гэх мэт</p> <p>4. Сурах бичгийн "Туслах уу" булангийн тайлбараас утгыг тодорхойлно. Мөн багштайгаа ярилцаж үгийн утга, түүхэн гарлыг мэднэ.</p> <p>5. Багшийнхаа дагуулан уншиж өгөх үед анхаарлаа төвлөрүүлэн даган амандаа уншиж, эргэлзээтэй болон уншиж чадахгүй байсан үгээ сайн сонсож авна. Уншихдаа үгийг хугаслан хэлэхгүй, авиа үсгийг дутуу дуудахгүй байх хэрэгтэй.</p> <p>6. Уншсан зүйлийнхээ утгыг тайлбарлан ярина.</p>  | <p>Сурах бичгийн 46, 50, 52, 54, 57, 59, 20, 28, 29, 39...–р хуудасны бичвэрүүд дасгал 7 (х.28) дасгал 10 (х.29) дасгал 1 (х.39) гм</p> <p>Багш сонгож авсан эх материалууд</p> <p>“ Монгол зуун билгийн дээж оршвой”</p> |



**БИЧИХ**

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн  |
|--|--|---|
| <p><b>9.2а.</b><br/>Бийрийн бичмэл хэлбэрийг дуурайн бичих</p> <p>Бийр, дармал, бичмэл хэлбэрийг дуурайн бичих</p> <p>Үндэсний бичгээр бичсэн хичээнгүй, дармал хулсан үзэг, таталган, сонгодог, бийр, эвхмэл, угалзан хэлбэрийн бүтээлийг уншиж судалснаар бусад хэлний бичгээс ялгаатай болохыг таньж өөрийн сонирхсон хэлбэрээр бүтээл бичдэг болох</p> | <p>Бийрийн бичлэгийн талаар 8-р ангидаа судалж мэдсэн мэдлэг чадвартаа тулгуурлан чадвараа улам сайжруулна. Дармал, бичмэл тигийг харьцуулан уншиж онцлог ялгааг нь мэдсэний дараа бийрийн бичлэгийн тигийг уншиж бичиж сурна.</p> <p>1. Бийрийн бичлэгийн зурлага, үсгийг таван шугамд яаж бичсэнийг ажиглах, нүдлэх, багшийгаа даган дуурайж бичих замаар нүдлэн тогтооно.</p> <p>2. Дармал, бичмэл, бийрийн тиг гэсэн бичлэгийн тигүүдийг харьцуулж ажиглах, нүдлэх, даган дуурайж бичнэ. Багшийгаа анхааралтай сонсож, бичихийг нь анхааралтай ажиглаж, таван шугамаа татаж бичиж эхэлнэ. Хичээнгүй сайхан бичих нь нэг удаа биш нэлээд хугацаанд уйгагүй оролдсоны дүнд буй болдог. Сурах бичгээс гадна бийрийн бичвэрийг цуглуулж солилцон хуулж бичиж болно. Дуурайн хуулахаас гадна дараах бүтээлч байдлаар бичиж болно.</p> <p>Эхлээд дармалыг уншина. Дараа нь хичээнгүй бичгийн тигээр бичсэнээ уншаад, хамгийн сүүлд нь бийрийн бичлэгийн тигээр бичсэнээ уншиж мэдлэг чадвараа батжуулна. Ингэж дармал, бичмэл, бийрийн тигийг түгдрэлгүй, шударга уншиж сурсны дараа:<br/>-эхийн утгыг ярих, эхээс ямар үг өгүүлбэр сонгон бичих болсноо тайлбарлах<br/>-утга адил зүйр үг эсвэл 1 өгүүлбэрээр санааг нь хураангуйлан бичих<br/>-хураангуйлснаа дэлгэрүүлж монгол бичгээр эх зохиож бичих... гэх мэт</p> | <p>Сурах бичгийн 20,28,29,39...-р гм хуудас</p> <p>интернет сайт, Н. Золжаргал “Бийрийн бичлэгт суралцах нь” г.м</p>  |
| <p><b>9.2б.</b><br/>Түүх, соёл, өв уламжлалын сэдэв бүхий дармал болон бийрээр бичсэн эхийг хичээнгүй тигээр бичих</p>   | <p>1. Эхийг уншина. Уншихдаа эх дуудлагаар нь уншина. Зарим үгийг гаргаж чадахгүй бол үеэр таслан \qa-ma-ya-la-qi\ хэлнэ.</p> <p>2. Уншиж чадахгүй үгээ дэвтэртээ бичнэ.</p> <p>3. Дэвтэртээ бичсэн үгээ утгат хэсгээр задална. Жишээ нь: \sang+na+gul+qi\ гэх мэт</p> <p>4. Сурах бичгийн "Туслах уу" булангийн тайлбараас утгыг тодорхойлно. Мөн багштайгаа ярилцаж үгийн утга, түүхэн гарлыг мэднэ.</p> <p>5. Багшийнхаа дагуулан уншиж өгөх үед анхаарлаа төвлөрүүлэн даган амандаа уншиж, эргэлзээтэй болон уншиж чадахгүй байсан үгээ сайн сонсож авна. Уншихдаа үгийг хугаслан хэлэхгүй, авиа үсгийг дутуу дуудахгүй байх хэрэгтэй.</p>   | <p>Сурах бичгийн 46, 50, 52, 54, 57, 59, 20, 28, 29, 39...-р хуудасны бичвэрүүд дасгал 7 (х.28) дасгал 10 (х.29) дасгал 1 (х.39) гм</p> <p>Багш сонгож авсан эх материалууд</p>                           |

|  |  |   |
|--|--|---|
| <p>Түүх, соёл, өв уламжлал бүхий монгол бичгийн хичээнгүй, дармал, хулсан үзэг, бийрийн хэлбэрээр бичсэн түүхэн зохиол судар бичгээс бичих</p> | <p>6. Уншсан зүйлийнхээ утгыг тайлбарлан ярина.<br/>9-р ангийн сурах бичгийн эхүүд нь хүн байгалийн хүйн холбооны талаар, монгол зан заншил, өв уламжлалын талаар, байгаль хамгаалах ёс, түүх төрт ёсны тухай голлосон бөгөөд бичихдээ хэсэглэн сонголт хийж бичиж болно. Тухайлбал:<br/>-Чингис хааны зарлиг болсон хэсгийг бичих<br/>-Дутуу орхисон хэсгийг нөхөн бичих<br/>-Тодруулсан хэсгийг дуурайн бичих<br/>-Борохулын хэлснийг хуулан бичих<br/>-Нэрээс үйл үг бүтээх дагавартай үгсийг түүж бичих<br/>-Асуултад хариулж бичих<br/>-Зөв дараалалд оруулж бичих<br/>-Хэлцийг шууд утгаар нь солин нарийуулж бичих ... гм</p>   | <p>“ Монгол зуун билгийн дээж оршвой”</p>   |
| <p>Үндэсний бичгийн толь бичиг ашиглан эх зохион бичих</p>   | <p>Эх зохиож бичихдээ дараах зүйлсийг анхаарна.<br/>1. Мэдээлэл цуглуулна.<br/>2. Өөрийн үзэл бодлыг тусгана. Тэгэхдээ түүнийгээ жишээ баримтаар баталж нотолно.<br/>3. Монгол хэлний хичээлээр эзэмшсэн арга барилд тулгуурлан баримт мэдээлллийг задлан шинжилж хүүрнэх, дүрслэн тоочих, тайлбарлах гм хэв маягийг дангаар болон хослуулан бичиж болно.<br/>4. Цэвэр сайхан, найруулгын алдаа (үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн...)-гүй бичнэ.<br/>5. Бичиж найруулахдаа бүтээврийн нийлц, цэг тэмдэг, утга ялгаж бичдэг үгс, уламжлалт бичлэгтэй үгсийг зөв бичнэ.<br/>6. Үндэсний бичгээр хэрэв зөв бичиж чадахгүй мэт эргэлзээтэй үгс гарвал толь бичгээс харж бичнэ. Үндэсний бичгийн толь бичигт дагавар, нөхцөлөөр хувилсан байдалтай байдаггүйг санах хэрэгтэй. Тиймээс толь бичгээс үгийн үндсийг бичиж аваад таньж мэдсэн дагавар нөхцөлүүдээ эр эм үг, хатуу зөөлөн дэвсгэрээ санаж, нэр үг бол зөв дагуулж, үйл үг бол зөв холбож бичнэ.<br/>Тухайлбал: зургийг хараад байгаль дэлхийн холбогдолтой ертөнцийн 3 , шүлэг, бичил эх зохиовол хүн бол байгаль дэлхийн дайсан болох, байгаль орчны хамгаалалт, дэлхийн дулаарал, байгалийн гамшиг, монголчуудын байгаль дэлхийгээ хайрлах ёс, ногоон байгаль, цэнхэр дэлхийн талаарх тоо баримт, байгаль дэлхий бол бидний хүнс, хоол тэжээл гэх мэт мэдээлэл цуглуулаад, "Хүн бол байгаль дэлхийн дайсан. Хүн мод тайрч байна, голын эх бохирдуулж байна, алт ухаж байна, ой модоо шатааж байна, ан амьтдыг устгаж байна..." гм үзэл бодлоо тусган, тоо баримтыг эш татаж эхээ зохион бичнэ. "Цэнхэр дэлхий, цэнгэг ус, цэвэр агаар болсон байгаль дэлхийгээ хүн төрөлхтөн бид өдрөөс өдөрт хэмлэн, ерөөс хүний хийж байгаа бүх зүйл байгаль дэлхийн эсрэг чиглэж байдаг гээд хэлчихэд нэг их буруудахгүй л байх..." гм дүрслэн тоочих, хүүрнэх бичлэгийн хэв маягийг хослуулна.</p> | <p>Үндэсний бичгийн толь<br/><br/>Монгол хэлний сурах бичиг</p>                       |
| <p>Гадаад үгийг толь бичиг ашиглан бичих,</p>  | <p>Гадаад үг, өгүүлбэрийг шударга уншиж бичихийн тулд:<br/>1. Гадаад үгийг нэмэлт зурлага (матгар шилбэ, сэртэн чих, доошоо харсан зартиг, малгайтай титэм ...) тэмдгээр нь ялгана. Жишээлбэл: "ба" үсгийн толгойд сэртэн чих нэмбэл "фа", ангархай гаргавал "Па", "гэ, хэ"- үсгийн толгойд богино шилбэ татвал "ка", титэм дээр малгай өмсгөвөл "ж", "н" үсэг дэвсгэрлэн, үл дэвсгэрлэн орсон ч ямаргт шүдний өмнө цэг тавина, "у" үсгийг үгийн дунд "ү", үгийн адагт "ү", "д" үсгийг үгийн эхэн, дунд, адагт "ү", "т" үсгийг "ү" -ээр бичдэг</p>   | <p>Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь<br/><br/>Үндэсний бичгийн толь</p> |

|   |   |   |
|---|---|---|
|   | <p>гм.<br/> 2. Тухайн хэлний үгийг уул бичигт яаж тэмдэглэдэг тэр л байдлаар шууд үсэгчлэн буулгадгийг ажиглаж таньсан байна. Жишээлбэл: кино, клуб, институт, мотор гм.<br/> 3. Гадаад үг болон гадаад үгийг зөв бичих дүрмийг толь бичгээс лавлан үзсэн байна.<br/> 4. Өдөр тутам хэрэглэдэг гадаад үгсээ үндэсний бичгээр бичихийн зэрэгцээ монгол үгээр хэрхэн нэрлэдгийг тогтооно.<br/> 5. Өдөр тутам хэрэглэдэг гадаад үгийг бүртгэн, толь бүтээнэ... Энэ мэт ажлуудыг алхам алхмаар хийж, байнга хэрэглэдэг идэвхтэй гадаад үгийг хэрхэн бичдэгийг нүдэлснээр гадаад үгсийг төвөггүй уншиж бичнэ.</p>  | <p>Монгол хэлний гадаад үгийн толь</p>  |
| <p><b>9.2в.</b><br/> Сурах бичгийн хүрэн дэх дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг толь бичиг ашиглан зөв бичих</p> | <p>Дуудлага бичлэг зөрүүтэй үгийн утгыг тайлбарлан уншина.<br/> - Харааны уншлагаар унших<br/> - Уншсан үгээ кириллээр бичих<br/> Үгийн утга тайлбарлах замаар уншсанаа дүгнэж хамгаалах "гараг", "гариг", "хир", "өөр", "өвөр" гм гэсэн үгийн утгыг холбоо үгээр илэрхийлнэ. "өөр" гэсэн үгийг монгол бичгээр "өбэр гэж бичсэн нь бичлэгийн .... онцлог байна" гм тайлбарлан хэлэх<br/> Үгийг зөв бичих<br/> - Үгийг кириллээр бичсэнийг хараад монгол бичгээр оноож бичих<br/> - Эхээс олж холбоо үг, өгүүлбэрийн хамт түүж бичих<br/> - Бичлэгийн онцлогоор төрөлжүүлэн бичих (дагавар нь ижил үгс, нэрээс үйл үг үүссэн үгс, үйлээс нэр үг үүссэн үгс, дуудлага ижил бичлэг өөр үгс...) Жишээ нь: "-с" –гэсэн дагаврыг ямар ямар утга байхыг олох, дараа нь монгол бичгийн бичлэгийг утгад оноон бичиж тогтооно. Үүнд:<br/> 1.Тэмдэг нэрээс үйл үг бүтээх "-с" дагавар нь тухайн шинж тэмдэг буй болохыг заасан утгатай бол "бүлийэс-", "багас-", "сирүгүс-", "йэхэс-" гм бичнэ. 2. Нэрээс үйл үг бүтээж тухайн зүйлийг хүсэх, хүртэх утгатай бол "михаса-", "хужирса-", "үгэсэ-", "агурса-" гм үндэсний бичгээр "-са" гэж бичнэ гм.<br/> Сурах бичиг дэх үгийн жагсаалтын хэд хэдэн хувилбартай карт бэлдэх<br/> Дуудлага бичлэг зөрүүтэй үгийн<br/> Дуудлага ижил, бичлэг зөрүүтэй үгийн<br/> Толгой үсгээр бүлэглэж бичих /агшин, айлга, аймаар, баахан, бамбарууш, гуйх, гүйх, давхар, дэд/ г.м<br/> Үгийн утгыг зургаар харуулах<br/> Дуудлага бичлэг зөрүүтэй үгийг чээжээр бичих<br/> Кириллээс буулгаж бичих /өглөө, гэнэт, худаг, гэрээ даалимба/<br/> Янз бүрийн үгийн жагсаалт өгч хуулан бичлэг хийх<br/> Эхийг хэд хэдэн удаа бүтээлчээр уншсаны дараа түүнд байгаа үгсийг толгой үсгээр нь тольчилж бичих, утгын тайлбар хийж бичих зэрэг янз бүрийн арга хэрэглэж болно.</p> | <p>Сурах бичгийн арын хавсралт толь</p> <p>Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь</p> <p>Үндэсний бичгийн толь</p> |

## ХЭЛЗҮЙ

| Суралцахуйн зорилт   | Сурах үйл ажиллагаа  | Хэрэглэгдэхүүн  |
|--|--|---|
| <p><b>9.3а.</b><br/>Нэр, үйл үг бүтээх хувилгагч эх хувилгагч дагаврыг холбох ёсны дагуу зөв залган бичих</p> <p>Үйл үг бүтээх дагаврыг холбох ёсны дүрмээр зөв бичих</p> <p>Нэр үг бүтээх дагаврыг холбох ёсны дүрмээр зөв бичих</p> <p>Тэмдэг нэр бүтээх дагаврыг холбох ёсны дүрмээр зөв бичих</p> <p>Нэр, үйл, тэмдэг нэр бүтээх</p> | <p>Үйл үндэс эгшгээр, мөн гийгүүлэгчээр төгсвөл "Б, Д, Р, С, Н, Г, Л" -ээр төгсдөгийг жишээгээр батална.</p> <p>Эгшиг болон гийгүүлэгчээр төгссөн хоёр үйл үгэнд хувилгагч залгавар (йа г н м л р -схий, -шгүй) залгаж бичнэ. Эдгээр залгаврыг залгахад бэрхшээлүүд гарч болно. (хэрэв дүрмээ мартсан бол)</p> <p>1. Шууд залгаж бичих. Үндэсний бичиг нь гийгүүлэгч давхарлан бичдэггүй учир шууд залган бичиж болохгүй.</p> <p>2. Шүд жийрэглэж бичих. А юмуу Э эгшгээр төгссөн үг нь үгийн дунд орохдоо шүд болдог учраас энэ нь мөн боломжгүй.</p> <p>3. Гэдэс жийрэглэж бичих. Б,Д, Р, Л, С, Н, Г-ээр төгссөн үйл үндсэнд хувилгагч залгавар залгахад дунд нь гэдэс жирэглэдэг болохыг мэднэ.</p> <p>Дээрх үйл ажиллагааг бие даан хийснээр үндэсний бичгийн зөв бичих ёсны талаарх дараах оюун дүгнэлтийг гаргасан байна.</p> <p>"Эгшгээр төгссөн бүх үг+ Бүх залгавар= Шууд залгана. Гийгүүлэгчээр төгссөн бүх үг +Т,Б,Х, Ж, Ч, С, Д ээс бусад гийгүүлэгчээр эхэлсэн залгавар = Гэдэс жийрэглэнэ."</p> <p>Энэхүү холбох ёсны дүрмээр үйл үг бүтээх, нэр үг бүтээх, тэмдэг нэр бүтээх зэрэг бүх дагаврыг холбон бичдэг тул зөв бичихэд нэг талаар амар. Гагцхүү үйл үг бүтээж байгаа, нэр үг бүтээж байгаа, тэмдэг нэр бүтээж байгаа дагавруудыг утгын хувьд ялган тогтоох нь чухал.</p> <p>Жишээ 1. Үйлээс нэр үг бүтээх "-уур, -үүр" дагавар нь 1.а. багаж хэрэгслийн, б. хүн, амьтны зан байдлын шинж заасан бол үндэсний бичгээр -гур, -гүр (галигаар: а. жингнэгүр, дэбигүр, хөдэлгэгүр б.долиганагур, ангалзагур гм.), 2. хэрэв уг үйлийн үр дүн болох хийсвэр юмны нэр заасан бол үндэсний бичгээр -гури, -гүри (зүдэгүри, ичигүри, зажилугүри, жигсигүри гм) гэж ялгаж бичдэгийг тогтооно.</p> <p>Жишээ 2. Нэрээс үйл үг бүтээх олон дагаврын дотроос -т (-ту, -тү), -д (-да, -дэ, -д) нэлээд сонин.</p> <p>а. цант- (цангту-), гэрэлт- (гэрэлтү-), мөст- (мөсүтү-), уст- (усутү-), үст-(үсүтү-) гэж цан, гэрэл, мөс, ус, үс зэрэг тухайн юмтай болох гэсэн утгатай бол -ту, -тү байдлаар</p> <p>б. уйд- (уйид-), бэлд- (бэлэд-), холд- (холад-), түргэд- (түргэд-) гэж тухайн нэрийн утгын дагуу үйл болох, үйлдэхийн утгатай бол дэвсгэр -д байдлаар</p> <p>в. багад- (багада-), богинод- (богунида-), холд- (холада-), түргэд- (түргэд-) гэж хэрээс хэтэрсэн, зохисгүйн утгатай бол -да, -дэ байдлаар</p> <p>г. үсд- (үсүдэ-), сүүлд- (сэгүлдэ-), бууд- (бууда-), ташуурд- (тасигурда-), цавууд- (цабауда-), чулууд- (чилагуда-) гэж тухайн зүйлийг барих, хэрэглэх утгатай бол -да, -дэ байдлаар тус тус утга ялган бичнэ.</p> <p>Дагавраар үг бүтээхдээ тухайн дагавар ямар утга зааж байгааг бодож бичнэ. Тухайлбал: богино+д= богинод- гэсэн үг бүтээж үндэсний бичгээр бичихдээ "Хавар болоод өдөр уртсаж, шөнө богинодож байна" гэсэн утгатай юу "Өмд</p> | <p>Үндэсний бичгийн сурах бичгийн хуудас 12-145</p> <p>Үндэсний бичгийн толь</p> <p>Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь</p> |

|  |   |  |
|--|---|--|
| <p>дагавартай<br/>үгсэд задлал<br/>хийж<br/>тайлбарлах</p> | <p>богинодож байна" гэсэн утгатай юу гэдгийг бодож "богунидчу" эсвэл "богунидажу" бүр "богунидучу" гэсний аль хэлбэрээр бичихээ шийднэ.</p> <p>хол+д=холд- гэсэн үг бүтээж үндэсний бичгээр бичихдээ "Өвөл болоход нар холдоно" гэсэн утгаар уу, "Гэр, сургуулийн хоорондох газар хүүхдэд холдоно" гэсэн утгаар уу гэдгийг, түргэн+д= түргэд- гэсэн үгийг "Усны урсгал түргэдэж байна" гэсэн утгаар уу, "Чи түргэдэж буруу хийжээ" гэсэн утгаар уу гэдгийг бодож бичнэ.</p> <p>А.Үндэсний бичгийн зөв бичихзүйн гол зарчим бол үгийн язгуур үндсийг эвдэхгүйгээр дагавар нөхцөлөө залгадаг оршино. Өөрөөр хэлбэл үгийн бүтцийг тогтвортой хадгалж бичихийг эрхэмлэдэг бичиг. Жишээ нь: "dagu-"гэсэн үйл язгуурт дагавар залгахад түүний язгуур нь тогтвортой хадгалагдаж daruqu, daruluqu, darulal, darumta, darumal</p> <p>Б. Үндэсний бичгийн үсэг нь эр, эм, саармаг эгшгийн зохицлын дүрэмтэй. Иймээс үгийн язгуур бүтээврийн араас угсран залгах дагавар нь эр, эм үгэнд залгах хоёрхон хувилбартай тул үг бүтээх аргаар нь үгсийг бүлэглэхэд тун хялбар байдгийг анзаарах.</p> <p>В. Зөв бичиж сурах бас нэг гол зүйл бол дагавар нөхцөлийг зөв дагуулах юм. Энэ нь ЭГЭ гэж салаавчлан ордог зүй тогтлын дагуу Э-ээр төгссөн үгэнд Г-ээр эхэлсэн, Г-ээр төгссөн бол Э-ээр эхэлсэн нөхцөл дагавар залгадаг зүй тогтлыг анзаарч мэдсэн бол амархан зөв бичиж сурна. Үгийг язгуур үндэс, дагавар, нөхцөлөөр нь задална. Үгийн язгуур, үндэс нь эгшгээр эсвэл хатуу, зөөлөн дэвсгэр гийгүүлэгч алинаар төгссөн болохыг тодорхойлно.</p> <p>Дагавар авч үүссэн үг бол нэр, үйл үг үүсгэх ямар утгатай дагавар болохыг тодорхойлох (сурах бичиг дэх дагавруудын утгыг тогтоох)</p> <p>Нөхцөлүүд нь нэр, үйлийн ямар бүтээвэр болохыг нэрлэнэ. Үгийг задлах нь үзсэн дагавраар үг бүтээж байсан, үзсэн нөхцөлөөр үг хувилгаж байсан ажлын өөр нэг хэлбэр юм.</p> |  |
|--|---|--|

Багшид зөвлөх нь:

Суралцагчдаар хичээнгүй сайхан бичүүлж хэвшүүлэх аргуудаас: а) Шугамын арга (Тухайн үсэг, үгийг хичээнгүй бичихдээ аль шугамын хаанаас эхэлж аль шугамын хаана хүргэн ямар шугамд яаж төгсгөхийг баримтлан бичихийг хэлнэ.) б) Баримжааллын арга (Голдуу үсэг зурлага үзэж буй үед хэрэглэнэ. Агаарт бичих, хэв дагуулан бичих) с) Тодруулан бичих арга (Энэ арга нь цэгийг тодруулах буюу сүүлийн үед калькан цаасан дээр тодруулан бичиж байна) d) Тооллын арга (Тооллын аргыг ангийн сурагчдын бичлэгийн хурдыг жигдрүүлэх зорилгоор хэрэглэдэг.) e) Даган дуурайлган бичих арга (Монгол бичгээр хичээнгүй бичихэд сургахад өргөн хэрэглэдэг аргын нэг) Багш энэ аргыг хэрэглэхдээ ажлын хуудсан дээрээ калькан цаас тавих эсвэл хичээнгүй бичгийн эхээ маш бүдэгхэн бичиж өгнө. f) Төрөлжүүлэн бүлэглэх арга (Үсгийн зурлагыг хөнгөнөөс нь хүндрүүлэн ижил төстэйгээр нь бүлэглэн бичнэ. Жишээ нь: Титэм ба шүдэт, шилбэт үсгийн бүлэг г.м.

Эдгээр аргын зарим нь 6-7 р ангийн түвшинд, заримыг нь 8-9 р ангийн түвшинд хэрэглэж болох ба тодруулан бичих арга, тооллын арга, даган дуурайлган бичих аргыг 9-р ангийн түвшинд хэрэглэж болно.

Үндэсний бичгийн зөв бичих ёсыг уламжлалт дүрмийн хүрээнд

- Хувилах үсгийн дүрэм

- Хатуу зөөлөн гийгүүлэгчийн зохицол

- Өвөрмөц хувилалтай үгс

- Нэрийн нөхцөлийг бичих гэж салангид таниулдаг. Энэ нь сурагчдын оюуны идэвхт үйл хийх үйлдэлд тэднийг татан оролцуулахад дутмаг байдаг нь практик дээр гарч ирдэг. Иймээс дүрмийг эгшиг жийрэглэх (о, е \a, e\, i), эгшиг хасагдах (о, е \a, e\, i), хоосноор холбох гэсэн 3 тогтолцоонд авч үзэн нэгдмэл ойлголтыг өгвөл монгол бичгээр зөв бичиж, язгуур бүтээвэр, залгавар бүтээврийн утга зүй тогтлыг бүрэн ухаарна. Өөрөөр хэлбэл монгол бичгийн зөв бичихзүйн гол асуудал нь

1. Язгуур бүтээвэр

2. Залгавар бүтээвэр

3. Холбох ёс гэсэн гурван ухагдахууныг ухаарах хэрэг юм. ЯЗГУУР холбох ёс ЗАЛГАВАР (Зогсонги Хөдлөнгө Зогсонги)

Үндэсний бичгийн зөв бичихзүйн гол зарчим бол үгийн язгуур үндсийг эвдэхгүйгээр дагавар нөхцөл залгадаг оршино. Өөрөөр хэлбэл үгийн бүтцийг тогтвортой хадгалж бичихийг эрхэмлэдэг бичиг.

Багш дараах хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй. 1. Үндэсний бичгийн үсэг нь эр эм саармаг эгшгийн зохицлын дүрэмтэй. Иймээс үгийн язгуур бүтээврийн араас угсран залгах дагавар нь эр, эм үгэнд залгах хоёрхон хувилбартай тул үг бүтээх аргаар нь үгсийг бүлэглэхэд тун хялбар байгааг сурагчдад ойлгуулах. 2. Зөв бичүүлж сургах бас нэг гол асуудал бол дагавар нөхцөлийг зөв дагуулах юм. Энэ нь монгол

бичиг нь ЭГЭ гэж салаавчлан ордог зүй тогтлын дагуу Э-ээр төгссөн үгэнд Г-ээр эхэлсэн, Г-ээр төгссөн бол –ээр эхэлсэн нөхцөл дагавар залгадаг зүй тогтлыг мэдүүлвэл сурагчид маш амархан зөв бичиж сурдаг болохыг ухамсарлан ойлгуулвал амархан ойлгож сурна.

Хичээлийг удирдан явуулахдаа сурагчдаар бие даан хийлгэх үйл ажиллагааны чиглэл өгвөл сурагчдын монгол бичгийн үгийн сан баяжиж, хэл яриа хөгжиж, үгийн утгыг ялган ухаарч ойлгоход үлэмж ач холбогдолтой.

Сурагчдад унших бичих чадвар бүрэн эзэмшсэний дараа монгол бичгээр найруулан бичих чадвар мэдлэгийг олгох гол сургалт нь эх зохион бичих юм. Эх зохион бичүүлж сургах хэд хэдэн арга байна.Тухайлбал:

А. Дуурайн зохиох. Зохион бичүүлэх зүйлээ багш өөрөө ярьж өгөөд түүгээр зохион бичүүлнэ. Энэ нь хүүхдийн сонирхол татсан явган үлгэр, зохиолчдын бичсэн богино өгүүллэг найруулал байж болно.

В. Багш сурагчдад хэд хэдэн тодорхой сэдэв өгч аль дуртай сэдвийг сонгуулан эх зохиолгож болно.

С. Хичээл дээр үзэж буй эхийн гол утга санааг дэлгэрүүлж эсвэл зүйр үгээр илэрхийлж эх зохиолгож болно.

Д. Сургаалын зохиолоор зурагт ном бүтээх, харилцан яриа зохиох, утгыг тайлбарлан гол санаагаар эх зохиох гэх мэт байж болно.

Багш туршлагадаа тулгуурлан сурагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх замаар бүтээлч идэвхтэй сургалтын арга эрэлхийлэн хичээлийн үр өгөөжийг заавал дээшилнэ гэдэгт анхаарвал зохино.

